




Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх
Статистикийн хэлтэс

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



ТАНИЛЦУУЛГА

/Малын тоо, бүтэц/

2013/02

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ (2013 ОНЫ ЭХНИЙ 02 САРЫН БАЙДЛААР)

I. ТӨСӨВ:

Төсвийн орлого

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор эхний 02 сард аймгийн төсөвт 13629.8 сая төгрөгийн орлого орохоос 13132.0 сая төгрөгийн орлого орж төлөвлөгөөний биелэлт 96.3 хувьтай байна.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 774.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 725.0 сая төгрөгийн орлогыг оруулжээ.


Аймгийн төсвийн орлогын 94.5 хувийг тусламжийн орлогоор, 4.9 хувийг орлогын албан татвараар, 0.2 хувийг өмчийн татвараар, 0.3 хувийг бусад албан татвараар, 0.1 хувийг татварын бус орлогоор бүрдүүлж байна.



Төсвийн зарлага

Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүнгээр 7924.0 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Нийт зарлагын 50.2 хувийг цалин хөлс, 4.4 хувийг НДШ, 0.9 хувийг ЭМД, 23.9 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 19.3 хувийг татаас ба шилжүүлэг, 1.3 хувийг хөрөнгийн зардал тус тус эзэлж байна.



Өглөг,авлага

Эхний 02 сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагууд 184.0 сая төгрөгийн өртэй байна.

Өглөгийн 23.9 хувийг түлш халаалтын зардал, 12.3 хувийг тээврийн зардал, 8.7 хувийг цалин, 8.1 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 19.7 хувийг хоолны зардал, 1.4 хувийг гэрэл цахилгааны зардал, 25.9 хувийг бусад зардал тус тус эзэлж

байна.Тухайн сард шинээр үүссэн өглөг 184.0 сая төгрөг буюу нийт өглөгийн 79.8 хувийг эзэлж байна.

II. АРИЛЖААНЫ БАНК.

Манай аймагт 2013 онд арилжааны 6 банкны салбар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд үйлчилгээ үзүүлж байна.Арилжааны банкны салбаруудаас аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл эхний 02 сард 85113.2 сая төгрөг болж, 58.3 хувь нь ХААН банк, 21.4 хувь нь Хадгаламж банк, 0.3 хувь нь Капитал банк, 2.4 хувь нь Төрийн банк, 17.5 хувь нь Хас банк-д ногдож байна. Зээлийн өрийн үлдэгдлийн 19.7 хувийг 2013 оны эхний 02 сард олгосон зээл эзэлж байна. Нийт зээлийн 0.4 хувь нь хугацаа хэтэрсэн зээл байна. Аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс 11646.9 сая төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн байна.

Байгууллага, иргэдийн хугацаатай ба хугацаагүй хадгаламж 40226.8 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнээс 11090.4 сая төгрөг буюу 38.1 хувиар өссөн байна.

III. НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ:

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 5719.0 сая төгрөг, зарлага 5257.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 2098.9 сая төгрөг буюу 57.9 хувиар, зарлага 1721.9 сая төгрөг буюу 48.7 хувиар тус тус өссөн байна.Нийгмийн даатгалын сайн дурын орлого 142.1 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 47.3 сая төгрөг буюу 49.8 хувиар, эрүүл мэндийн сангийн орлого 123.8 сая төгрөг буюу 44.9 хувиар өсчээ. Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 4765.1 сая төгрөг болсны 80.3 хувийг өндөр настны, 12.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 6.8 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр 1.3 пунктээр өсч, өндөр насны тэтгэвэр 1.5 пунктээр буурсан байна.

Аймгийн хэмжээнд 12359 хүнд тэтгэвэр олгосны дотор өндөр насны тэтгэврийг 9483 хүнд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврийг 1904 хүнд, тэжээгчээ алдсаны тэтгэврийг 972 хүнд тус тус олгожээ.

Эхний 02 сард 325 хүнд 129.9 сая. төгрөгийн тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс тэтгэмж авагчдын тоо 3 хүнээр буюу 0.9 хувиар буурч,олгосон тэтгэмжийн хэмжээ 31.3 сая төгрөг буюу 31.8 хувиар өссөн байна.

Эмнэлэгийн санхүүжилтэд 315.5 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 21.3 сая төгрөг буюу 7.3 хувиар, ажилгүйдлийн тэтгэмж 39.6 сая төгрөг буюу 6.2 дахин өсчээ.

Нийгмийн халамж:


Эхний 02 сард нийгмийн халамжийн сангаас 19230 хүнд 2318.6 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо 789 хүнээр буюу 4.3 хувиар өсч, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 712.0 сая.төгрөг буюу 44.3 хувиар өссөн байна.Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж авагчдын 13.5 хувь нь халамжийн тэтгэвэр авагчид, 4.9 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэд, 6.8 хувь нь ахмад настанг асарч буй иргэд, 0.2 хувь нь алдар цолтой ахмадууд, 44.9 хувь нь алдарт эхийн одонтой эхчүүд байна.Нийгмийн халамжийн сангаас 2318.5 сая.төгрөгийн тэтгэвэр тэтгэмж олгосны 497.7 сая.төгрөг буюу 21.5 хувийг халамжийн тэтгэвэрт, 233.9 сая төгрөг буюу 10.0 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд, 13.2 сая төгрөг буюу 0.6 хувийг алдар цолтой

ахмадуудад, 101.6 сая төгрөг буюу 4.4 хувийг ахмад настанг асарч буй иргэдэд, 79.4 сая төгрөг буюу 3.4 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэдэд тус тус олгожээ.

IV.ХӨДӨӨ АЖ АХУЙ:


Аймгийн хэмжээгээр 2012 оны эцэст төллөх насны нийт 1190.5 мянган эх мал тоологдсон. 2013 оны эхний 2 сарын байдлаар 11.0 мянган мал буюу оны эхэнд тоологдсон нийт эх малын 0.9 хувь нь төллөсөн байна. Ингэний 0.1 хувь, гүүний 0.002 хувь, үнээний 0.2 хувь, эм хонины 1.1 хувь, эм ямааны 0.9 хувь нь төллөжээ.

Мал төллөлтийн хувь, 2013 оны эхний 2 сарын байдлаар




Гарсан төл 100.0 хувь буюу 11.0 мянган төл бойжиж байна. Өмнөх оны мөн үед төл бойжилтын хувь мөн 100.0 хувь байсан байна.

Төл бойжилтын хувь, 2013 оны эхний 2 сарын байдлаар




Аймгийн хэмжээгээр 2013 оны эхний 2 сарын байдлаар 1 тэмээ, 266 адуу, 328 үхэр, 1913 хонь, 2357 ямаа буюу оны эхэнд тоологдсон нийт малын 0.16 хувьтай тэнцэх 4865 том мал зүй бусаар хорогдоод байна.

Зүй бусаар хорогдсон том мал, 2012 оны эхний 2 сарын байдлаар




Нийт хорогдсон малын 0.02 хувийг тэмээ, 5.5 хувийг адуу, 6.7 хувийг үхэр, 39.3 хувийг хонь, 48.4 хувийг ямаа эзэлж байна.

Зүй бусаар хорогдсон том малын бүтэц, төрлөөр



2013 оны эхний 2 сарын байдлаар Бат-Өлзий суманд 1023 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.8 хувь, Баруунбаян-улаан суманд 337 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.3 хувь, Гучин-Ус суманд 196 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.2 хувь, Есөнзүйл суманд 60 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.05 хувь, Өлзийт суманд 20 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.02 хувь, Зүүнбаян-Улаан суманд 627 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.6 хувь, Нарийн тээл суманд 173 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.1 хувь, Тарагт суманд 2019 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.2 хувь, Төгрөг суманд 1 толгой мал, Уянга суманд 175 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.09 хувь, Хайрхандулаан суманд 126 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.07 хувь, Хужирт суманд 1011 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.7 хувь, Хархорин суманд 913 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.5 хувь, Арвайхээр суманд 2 толгой мал тус тус зүй бусаар хорогдсон байна. Бусад суманд том малын хорогдол гараагүй байна.

Зүй бусаар хорогдсон малын тоо, сумаар



Аймгийн хэмжээнд 2013 оны эхний 2 сард өвчнөөр 10 толгой мал Хархорин суманд хорогдсон байна. Урд оны мөн үед өвчнөөр мал хорогдоогүй байсан байна.


Хээлтэгчийн хорогдол эхний 2 сарын байдлаар 971 толгой байгаа ба оны эхний хээлтэгчийн 0.03 хувь нь хорогдоод байна. Нийт хорогдлын том малын 20.0 хувь нь хээлтэгч мал байна.

V. АЖ ҮЙЛДВЭР:

Үйлдвэрийн газрууд оны үнээр эхний 2 сард 1955.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 1872.2 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс бүтээгдэхүүний үйлдвэрлэл 13.5 хувиар, борлуулалтын орлого 14.5 хувиар өссөн байна.


Энэхүү өсөлтөд нүүрс олборлолт, цэвэр ус, талх, нарийн боов, хэрчсэн гурил, гутал, оёдол, модон эдлэл зэрэг үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.9 хувиас 5.2 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Үйлдвэрлэл явуулсан цэг салбарыг мэдээнд нэмж хамруулсан нь аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний өсөлтөд зохих хэмжээгээр нөлөөллөө.

Хүнсний зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 353.5 сая төгрөг, боловсруулах аж үйлдвэрийн салбарынх 922.8 сая төгрөг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн салбарынх 595.8 сая төгрөгт хүрч, нийт борлуулалтад уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 18.9 хувь болж 2.1 пунктээр буурч, боловсруулах аж үйлдвэрийн салбарынх 49.3 хувь болж 5.3 пунктээр өсч, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн салбарынх 28.7 хувь болж 2.8 пунктээр буурчээ.

Борлуулсан бүтээгдэхүүн салбарын бүтцээр




VI. ХОЛБОО, ТЭЭВЭР, ХУДАЛДАА:

Тээвэр

Авто замын тээврээр 2013 оны эхний 2 сард давхардсан тоогоор 29.8 мянган зорчигч зорчиж, 3.0 мян. тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс зорчигчдын тоо 4.7 мян. хүн буюу 18.7 хувь, тээсэн ачаа 0.3 мян.тн буюу 11.1 хувиар өсчээ.

Зорчигч эргэлт, тээсэн ачаа



Тээсэн ачаа, зорчигчдын тоо өссөнөөр авто замын тээврийн салбарын орлого 2013 оны эхний 2 сард 200.8 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 38.2 сая төгрөг буюу 23.5 хувиар өсчээ.

Холбоо

Холбооны тарифын орлого өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 9.0 хувиар өсч 51.2 сая төгрөг болсоны дотор хүн амаас орсон орлого 76.2 хувиар өсч 15.1 сая төгрөгт хүрсэн байна. Телефон цэгийн тоо 1019 байгаа нь урьд оны мөн үеийнхээс 20-оор буурсан байна.

VII. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ:

Сар бүрийн 15-21 ний байдлаар хүн амын өргөн хэрэглээний 12 бүлгийн 213 нэрийн барааны үнийн өөрчлөлтийг судалж түүний үндсэн дээр инфляцыг тооцдог.

2013 оны 02 дүгээр сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарыхаас 0.6 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 8.2 хувиар, 2010 оны 12-р сарынхаас 21.6 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн 01 дүгээр сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан 213 нэрийн бараа үйлчилгээний үнэ тарифын 19.7 хувийх нь үнэ өсч, 2.3 хувийх нь буурч, 78.0 хувийх нь үнэ тогтвортой байлаа.

Энэ сард өмнөх сарынхаас үнээний сүү 8.7 хувиар, чанасан хиамны үнэ 10.0 хувиар, зөөлөн чихрийн үнэ 2.6 хувиар, дээлийн даавууны үнэ 8.3 хувиар, эрээн

даавууны үнэ 8.7 хувиар, 1-р гурилын үнэ 6.7 хувиар, 2-р гурилын үнэ 8.3 хувиар, маслоны үнэ 2.9 хувиар, алимны үнэ 11.1 хувиар, мандарины үнэ 10.0 хувиар, үзэмний үнэ 7.1 хувиар, лууван, байцааны үнэ 10.0 хувиар, сонгиноны үнэ 15.8 хувиар тус тус өссөн байна.

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 58.6 хувийх нь буюу 125 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 8.4 хувийх нь буюу 18 нэрийн барааны үнэ буурч, 33.0 хувийх нь үнэ тогтвортой байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс сүү, элсэн чихэр, аарц, гурил, будаа, хүнсний ногоо, тамхи, архи, дотуур, гадуур хувцас, гутал, гэр ахуйн хэрэгсэл, жимс, жимсгэнэ, бүх төрлийн мах, бензин, зэргийн үнэ 1.3-72.6 хувиар нэмэгдсэн байна.

VIII. НИЙТ БАРАА ГҮЙЛГЭЭ:

Аймгийн хэмжээнд худалдаа эрхлэгч аж ахуйн нэгж, цэг салбарууд 2013 оны эхний 02 сард 7360.3 сая төгрөгийн бараа гүйлгээ хийсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1355.1 сая төгрөг буюу 22.5 хувиар өссөн байна. Аж ахуй нэгж иргэдийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 70 цэгээр буюу 5.8 хувиар өсчээ.

Бараа гүйлгээний орлого өмнөх оны мөн үеийнхээс 22.5 хувиар өсөхөд барааны дэлгүүрийнх 41.0 хувиар, хүнсний дэлгүүрийнх 27.4 хувиар, авто сэлбэгийнх 23.8 хувиар, цайны газрынх 12.2 хувиар, авто засварын газрынх 25.0 хувиар, шатахуун борлуулалтынх 17.5 эм борлуулалтынх 30.0 хувиар өссөн нь нөлөөлжээ. Барааны үнийн өсөлт нь бараа борлуулалт үнийн дүнгээр өсөхөд нөлөөлж харагдаж байна.

Бараа гүйлгээний орлогын 5.0 хувийг барааны дэлгүүр 24.0 хувийг хүнсний дэлгүүр, 3.0 хувийг авто сэлбэгийн дэлгүүр, 0.9 хувийг барилгын материалын дэлгүүр, 2.7 хувийг ресторан бар, 1.3 хувийг цайны газар, 0.2 хувийг түц 3.9 хувийг контейнер, 2.4 хувийг авто засварын газар, 53.7 хувийг шатахуун борлуулалт, 2.7 хувийг эм борлуулалтын орлого эзэлж байна.

IX. АЖЛЫН ШИНЭ БАЙР:

Аймгийн хэмжээнд 02 сарын байдлаар 166 ажлын байр шинээр бий болж өмнөх оны мөн үеийнхээс 3.3 дахин өссөн байна.

Ажлын байрны 12.0 хувь нь ХАА-н салбарт, 3.0 хувь нь боловсруулах үйлдвэрт, 42.2 хувь нь барилгын салбарт, 3.0 хувь нь худалдааны салбарт, 39.8 хувь нь бусад салбарт бий болжээ.

X. ЭРҮҮЛ МЭНД:

Аймгийн хэмжээнд эхний 02 сард 433 эх амаржиж, өмнөх оны мөн үеийнхээс 28 эхээр буюу 6.9 хувь, төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлтөөр) 435 болж, 27 хүүхэд буюу 6.6 хувиар өссөн байна.

Нэг хүртэлх насандаа 8 хүүхэд эндэж өмнөх оны мөн үеийнхээс 5 хүүхдээр буюу 38.5 хувиар буурсан байна.

Халдварт өвчнөөр эхний 02 сард 422 хүн өвчилж өмнөх оны мөн үеийнхээс 199 хүнээр буюу 89.2 хувиар өссөний дотор тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 8 хүн буюу 80.0 хувиар, салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 15 хүнээр буюу 2.0 дахин, сүрьеэгээр өвчлөгчдийн тоо 3 хүнээр буюу 21.4 хувиар, гахай хавдраар өвчлөгчдийн тоо 275 хүнээр буюу 20.6 дахин өсч, вирус гепатитаар өвчлөгчдийн тоо 92 хүнээр буюу 2.6 дахин, трихоминазаар өвчлөгчдийн тоо 11 хүнээр буюу 12 дахин буурчээ. Халдварт өвчин өмнөх оны мөн үеийнхээс Баян-Өндөр суманд 13 хүнээр, Сант суманд 8 хүн буюу 9.0 дахин, Төгрөг суманд 3 хүн буюу 2.5 дахин, Хархорин суманд 30 хүн буюу 16.0 дахин, Арвайхээр суманд 262 хүн буюу 6.7 дахин, Хужирт суманд 12 хүн буюу 2.2 дахин өсч, Бат-Өлзий суманд 6 хүнээр буюу 4.0 дахин, Баянгол суманд 2 хүнээр буюу

25.0 хувиар, Богд суманд 16 хүнээр буюу 17.0 дахин, Тарагт суманд 4 хүнээр буюу 40.0 хувиар,Хайрхандулаан суманд 13 хүн буюу 3.2 дахин, буурчээ.Арвайхээр суманд гахайн хавдраар 243 хүн, Хархорин суманд 23 хүн, Тарагт суманд 2 хүн, Төгрөг суманд 1 хүн, Баянгол суманд 5 хүн, Гучин ус суманд 2 хүн, ЗБУлаан суманд 1 хүн, Хайрхандулаан суманд 1 хүн, Хужирт суманд 11 хүн тус тус өвчилжээ.

ХИ.ГЭМТ ХЭРЭГ:

Аймгийн хэмжээнд 02 сард 102 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 8 гэмт хэргээр буюу 7.3 хувиар буурсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 59.8 хувь нь сумдад, 40.2 хувь нь аймгийн төвд бүртгэгджээ.

Хүүхэд оролцсон гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхтэй адилхан байна. Хулгайлах гэмт хэргийн 46.4 хувийг иргэдийн орон байрны хулгай, 53.6 хувийг малын хулгай тус тус эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс ЗБУлаан суманд 2.0 дахин, Богд суманд 4.0 дахин, Баянгол суманд 2.0 дахин, Гучин ус суманд 50.0 хувиар, Уянга суманд 50.0 хувиар, Хужирт суманд 50.0 хувиар өсч, Баян-Өндөр суманд 66.7 хувиар, Бүрд суманд 42.9 хувиар, Бат-Өлзий суманд 44.5 хувиар, Сант суманд 66.7 хувиар, Тарагт суманд 2.3 дахин, Хархорин суманд 21.5 хувиар тус тус буурсан байна.

Гэмт хэрэгт холбогдсон 77 сэжигтэн, яллагдагчийн 32 хүн буюу 41.5 хувь нь 18-35 хүртэл насных, 43 хүн буюу 55.8 хувь нь 35-аас дээш насных, 2 хүн буюу 2.6 хувь нь 17 хүртэлх насныхан байна. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын 1.3 хувь нь оюутан, 7.8 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 29.8 хувь нь малчин, 49.3 хувь нь ажилгүй иргэд байна.

Түр саатуулсан тээврийн хэрэгсэл 738 болж өмнөх оны мөн үеийнхээс 283 тээврийн хэрэгсэлээр буюу 27.7 хувиар, авто машин жолоодох эрхээ хасуулсан жолооч 54 хүнээр буюу 53.0 хувиар буурсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 15.7 хувь нь гудамж талбайд үйлдэгдсэн байна.Нийт хэргийн 34.3 хувь нь согтуугаар, 8.8 хувь нь бүлэглэн үйлдсэн хэргүүд эзэлж байна.

Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 14.2 хувиар өсч, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 23.9 хувиар буурчээ.

Гэмт хэргийн улмаас 87.5 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеийнхээс 24.4 сая төгрөг буюу 38.7 хувиар өсчээ. Нийт хохирлын 69.2 хувь буюу 60.6 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэргийн улмаас 14 хүн нас баржээ. Үүний 21.4 хувь нь хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас, 64.3 хувь нь золгүй учирлаар, 14.3 хувь нь бусдын гарт амь үрэгдсэн байна. Эмэгтэйчүүд оролцсон гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 2.0 дахин өсчээ.

Аймгийн хэмжээнд 02 сард 256 хүн эрүүлжүүлэгдэж, 52 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс эрүүлжүүлэгдсэн хүний тоо 14 буюу 5.8 хувиар өсч, баривчлагдсан хүний тоо 39 буюу 42.9 хувиар буурсан байна.



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД
MAIN INDICATORS

3/6/2013

Үзүүлэлтүүд	/Indicators/	Хэмжих нэгж /Unit/	2011	2012	2013	2012/ 2011%
Төсвийн орлого	/budget revenue/	сая.төг mln.tog	541.3	441.2	725	164.3
Төсвийн зарлага	/Budget expenditure/	сая.төг mln.tog	5589.7	8904.9	7924.0	89.0
Зээлийн өрийн үлдэгдэл	/Remainder of loan debts/	сая.төг mln.tog	37955.5	66502.0	85113.2	128.0
Үүнээс: хугацаа хэтэрсэн	/whom: outstanding debts/	сая.төг mln.tog	210.3	238.7	344.4	144.3
Хадгаламж	/Deposits/	сая.төг mln.tog	22735.3	29136.4	40226.8	138.1
Төллөсөн хээлтэгч	/Breeding stock/	мян.тол /thous.heads/	4.1	12.6	11	87.3
Бойжсон төл	/rearing of young animals/	мян.тол /thous.heads/	4.1	12.6	11	87.3
Том малын зүй бус хорогдол	/Losses of adult animals/	мян.тол /thous.heads/	7.6	0.4	4.8	7 дах
Аж үйлдвэрийн НБ	/Gross industrial outrut/	сая.төг mln.mog	1032.3	1722.1	1955.1	113.5
Борлуулсан бүтээгдэхүүн	/Sold production/	сая.төг mln.tog	955.3	1634.1	1872.1	114.6
Тээсэн ачаа	/Carried freight/	мян.тн /thous.tn	2.3	2.7	3	111.1
Зорчигч зргэлт	/Passenger turnover/	мян.хүн.км /thouspass.km/	5430.1	5522.0	6820.4	123.5
Холбооны орлого	/Revenue of communication/	сая.төг mln.tog	42.2	50.7	51.2	101.0
Телефон цэг	/Number of telephones/	тоо/number/	1127	1039	1019	98.1
Ажилгүйчүүд /Unemployment/		хүн/people/	2325			#DIV/0!
Халдварт өвчнөөр өвчлөгчид cases/	/number of infectious disease	хүн/people/	248	223	422	189.2
1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	/infant deaths at age of 1 years/	хүн/people/	11	13	8	61.5
Бүртгэгдсэн хэрэг/Offences/		тоо/number/	78	110	102	92.7
Хэрэгт холбогдогсод /Offenders/		хүн/people/	61	101	77	76.2

1.ТӨСӨВ

BUDJET

I.1 АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО,оны үнээр,мян.төг

STATE BUDGET REVENUE OF AIMAG, at current prices, thous.tog

Төсвийн орлого	гүйц	2013		Budget revenue
	2012	төл	гүйц	
Татварын орлого	414935.6	773722.8	712770	Tax revenue
Орлогын албан татвар	358609	748419.6	649970.6	-Individuals
- Өмчийн татвар	8240.7	10639.6	26019.3	-Property tax
- Бусад татвар	47018	13263.6	37599.2	-Other tax
Татварын бус орлого	20608.2	1272	10828.4	Non-tax revenue
Хөрөнгийн орлого	5669.6		1474.8	Capital revenue
Дүн	441213.4	774994.8	725073.2	Total

Орлогын эх үүсвэр

Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг	1000000	2527900.0	2527900.0	-Corporate tax
Аймагт орох татварын орлого	176710	746671.2	602998.0	-Value added tax
Суманд орох татварын орлого	39092.4	27051.6	59360.2	-Excise tax
Дүн	1215802.4	3301622.8	3190258.2	Total

I.1 АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА,оны үнээр,мян.төг

STATE BUDGET EXPENDITURE OF AIMAG, at current prices, thous.tog

Төсвийн зарлага	гүйц	2013		Budget expenditure
	2012	төл	гүйц	
-Цалин хөлс	3718061	4532545.9	3979246.5	-Wages&salaries
-Нийгмийн даатгалын шимтгэл	282680	421215	348234.2	-Social security contribution
-Эрүүл мэндийн даатгал	59884.3	81185.8	69344.3	-Health insurance
-Бараа үйлчилгээний бусад зардал	2072741	2943671.4	1891530.4	-Goods and services expenses
Татаас ба шилжүүлэг	2277902	1948320.2	1533578.2	-Subsidie & transfers
-Хөрөнгө оруулалт	493717.4	4200	102133	-Investment
НИЙТ ЗАРДАЛ	8904985	9931138.3	7924066.6	TOTAL EXPENDITURE

06-Mar-13

СЭЗТСХ-ийн мэдээг үндэслэв.

1.2 ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА сумаар, оны үнээр, мян.төг
 BUDGET REVENUE, EXPENDITURE ,by soum , at current prices , thous.tog

Сум	Орлого Revenue			Зарлага Expenditure		
	2012			2012		
	төл	гүйц	%	төл	гүйц	%
Баян-Өндөр	8340.0	13827.1	165.8	304742.8	242154.9	79.5
Бүрд	10502	9719.7	92.6	254817.7	233202.0	91.5
Бат-Өлзий	15560	35995.9	231.3	551610.9	430645.6	78.1
ББ-Улаан	11245.2	10788	95.9	269655.2	226750.8	84.1
Баянгол	13266.8	11940	90.0	324179.2	263840.8	81.4
Гучин-Ус	11281.6	10241.2	90.8	257178.7	220273.4	85.6
Есөнзүйл	8198	8751.3	106.7	307460.8	200966.3	65.4
Өлзийт	8524.8	7875.5	92.4	237349.3	180970.4	76.2
ЗБ-Улаан	11700.6	10066.2	86.0	263451.3	226972.8	86.2
Богд	19600	14301.7	73.0	405977.9	337573.0	83.2
Нарийнтээл	19581.6	15797.4	80.7	335921.4	263081.3	78.3
Сант	14208.2	12556	88.4	296059.0	239745.9	81.0
Тарагт	11708.6	9286.1	79.3	269188.6	232750.1	86.5
Төгрөг	10518	11180.2	106.3	294054.6	259465.1	88.2
Уянга	31612	19117	60.5	687478.6	438442.6	63.8
Хайрхандулаан	11282.4	12397.1	109.9	282716.2	228111.0	80.7
Хужирт	28893	34313.8	118.8	561343.7	436884.9	77.8
Хархорин	111372.0	85390.5	76.7	900291.6	743352.8	82.6
Арвайхээр	417600	391528.5	93.8	1895650.6	1644987.7	86.8
Сум дүн Soum total	774994.8	725073.2	93.6	8699128.1	7050171.4	81.0
Аимгийн шууд	0.0	0	-	1232010.2	873895.2	70.9
Аймаг дүн Aimag total	774994.8	725073.2	93.6	9931138.3	7924066.6	79.8

06-Мар-13
 СЭЗТСХ-ийн мэдээг үндэслэв.

ӨГЛӨГИЙН МЭДЭЭ

6/3/2013

	Нийт өглөг	Үүнээс:									
		Ажиллагсдад олгох цалин	Нийгмийн даатгалын шимтгэл	мэндийн даатгалын шимтгэл	Гэрэл цахилгаан	Түлш халаалт	Тээвэр	Шуудан холбоо	Хоол	Эм	Бусад
Эхний үлдэгдэл	65021.0	12695.1	2950.3	0	1859.3	2540.7	8575.9	175.7	14523	0	21700.6
Тухайн сард төлөгдсөн өглөг	18333.5	1351.1	1789.7	0	119.3	2242.1	4430.3	0	6399	0	2001.6
Тухайн сард шинээр үүсэн өглөг	184058.3	8860.8	17631.9	0	1602.3	54991.2	24294.9	563.8	37412	4297	34404.5
Эцсийн үлдэгдэл	230745.8	20204.8	18792.5	0	3342.3	55289.8	28440.5	739.5	45536	4297	54103.5
өглөг үүсэн хугацаа	31-60 өдөр	226780.7	18792.5	0	3342.3	55289.8	24940.5	739.5	45536	4297	53638.4
	61-120 өдөр	3965.1	0	0	0	0	3500	0	0	0	465.1
	121 өдрөөс дээш	0.0	0	0	0	0	0	0	0	0	0

БАНКНЫ КАССЫН ОРЛОГО, ЗАРЛАГА /мян.төг/

6/3/2013

д/д	Үзүүлэлтүүд <i>Indicators</i>	ХААН банк	Хадгаламж банк	ХАС банк	Төрийн банк	Капитал банк	Голомт банк
1	Монгол банкнаас арилжааны банкуудад хийсэн зузаатгал	294386.0	2247153.0	244000.0	220000.0	55000.0	525222.0
2	Банкны кассын орлого	9530000.0	29126596.1	7284078.2	778632.0	665923.3	3912790.1
3	Монгол банкинд гүйлгээнээс орсон татаас	7683810.0	411560.0	1397500.0	0.0	97500.0	673000.0
4	Банкны кассын зарлага	3051598.0	28902380.5	7069117.6	752108.0	634498.9	3764506.7
5	Зээлийн өрийн бүх үлдэгдэл	49660084.0	18221049.8	14919904.9	2048885.0	263259.0	0.0
6	Үүнээс: Хугацаа хэтэрсэн зээл	182363.0	4360.8	157024.5	566.0	0.0	0.0
7	Байгууллага, иргэдийн хувийн хадгаламж	22468315.0	8992716.7	6789128.2	360169.0	287320.7	1329223.7
8	Дүн	92870556.0	87905816.9	37860753.4	4160360.0	2003501.9	10204742.5

Нийгмийн даатгалын сангуудын зарцуулалтын мэдээ

мян.төг

МЯЛ:101

Үзүүлэлтүүд							Өссөн дүнгээр			
1	Нийгмийн даатгалын сангуудын нийт орлого					Төлөвлөгөө	5481636.4			
						Гүйцэтгэл	5719037.5			
						Хувь	104.3			
	Орлого	Үүнээс	Төсвийн дотац			Төлөвлөгөө	3887471.6			
						Гүйцэтгэл	3887471.6			
						Хувь	100.0			
			НДШ-ийн орлого			Төлөвлөгөө	1594164.8			
						Гүйцэтгэл	1831565.9			
						Хувь	114.9			
		Үүнээс	Нийгмийн даатгалын сайн дурын орлого			Төлөвлөгөө	67214.1			
						Гүйцэтгэл	142156.9			
						Хувь	211.5			
			Үүнээс	ЭМД-ын сангийн орлого		Төлөвлөгөө	384120.5			
						Гүйцэтгэл	399206.3			
						Хувь	103.9			
				Үүнээс	ЭМД-ын хураамж	Төлөвлөгөө	20800.0			
						Гүйцэтгэл	45494.5			
Хувь	218.7									
2	Зарлага	Тэтгэвэр				Хүний тоо	12359			
						Олгосон нь	4765180.4			
		Үүнээс	Өндөр настны		Хүний тоо	9483				
					Олгосон нь	3828369.3				
			ХБИргэдийн		Хүний тоо	1904				
					Олгосон нь	608842.7				
		Тэжээгчээ алдсаны		Хүний тоо	972					
				Олгосон нь	327968.3					
		Тэтгэмж				Хүний тоо	325			
						Олгосон нь	129991.6			
		Эмнэлгийн санхүүжилт				Олговол зохих нь	315502.2			
						Олгосон нь	315502.2			
		Ажилгүйдлийн тэтгэмжид олгосон				Хүний тоо	91			
						Олгосон нь	47159.8			
		3	НДШ-ийн авлага					Бүгд		31437.8
								үүнээс	аж ахуйн нэгж	12892.9
	төсвийн								18544.9	

06-Mar-13

НДХ-ийн мэдээг үндэслэв.

НДС-уудын зарцуулалтын мэдээ /сумдаар/

	НДШимтгэлийн орлого			Зарлага							
				Тэтгэвэр		Тэтгэмж		Эмнэлгийн санхүүжилт		Ажилгүйдлийн тэтгэмж	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Хүний тоо	Олгосон	Хүний тоо	Олгосон	Олговол зохих	Олгосон	Хүний тоо	Олгосон
БаянӨндөр	30542.4	33063.1	108.3	543	199015.9	6	3084.3			4	2418.6
Бүрд	26638.0	30337.2	113.9	364	135544.7	5	3686.5			1	168.8
БатӨлзий	48080.4	64554.1	134.3	529	196548.4	16	5610.1			1	668.1
ББ-Улаан	26218.5	25642.9	97.8	241	88458.6	3	1758.8			2	2100.0
Баянгол	34872.7	36444.7	104.5	389	139520.1	7	1186.5			1	198.6
Гучин-Ус	25030.6	29571.6	118.1	196	72117.7	7	4345.0			2	1307.8
Есөнзүйл	29173.9	25370.4	87.0	394	146543.4	3	376.2			2	557.3
Өлзийт	23939.5	26227.9	109.6	322	117366.8	3	617.3			3	3753.2
ЗБ-Улаан	27208.4	27372.9	100.6	415	146747.2	3	2441.1			3	2488.4
Богд	36745.3	42097.3	114.6	388	146038.5	9	3912.9			3	2640.5
Нарийнтээл	45146.4	53330.4	118.1	347	131413.2	4	980.2			2	798.2
Сант	32897.3	36921.6	112.2	440	159689.0	11	2190.2			3	3099.7
Тарагт	25701.9	27669.5	107.7	300	109528.5	9	5180.1			2	2229.9
Төгрөг	26196.3	31266.8	119.4	251	93097.1	8	3368.1			3	3346.9
Уянга	75505.2	63575.6	84.2	742	261771.7	17	6051.4			4	1922.7
Х-дулаан	31849.8	36448.9	114.4	358	128602.5	7	1836.1			3	2386.4
Хужирт	86066.7	85422.9	99.3	936	361636.0	29	10114.8			2	547.2
Хархорин	215534.7	233867.5	108.5	1845	734885.1	43	17073.1	76637.4	76637.4	16	7123.3
Арвайхээр	746816.8	922380.4	123.5	3359	1396655.8	135	56178.9	238864.8	238864.8	34	9404.2
Дүн	1594164.8	1831565.7	114.9	12359	4765180.2	325	129991.6	315502.2	315502.2	91	47159.8

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ХӨНГӨЛӨЛТИЙН
МЭДЭЭ**

Үзүүлэлт	Хамрагдсан хүн	Дүн
зарлага	19230	2318586.2
Халамжийн тэтгэвэр	2600	497744.5
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	2374	191687.3
Ахмад настныг асарч буй иргэнд НМТ	1308	101643.1
ХБ-тэй иргэнийг асарч буй иргэнд НМТ	937	79390.4
Бүтэн өнчин хүүхэд үрчилж авсны тэтгэмж	106	8677.6
Бусад	23	1976.2
Төрөлжсөн асрамж үйлчилгээний зардал	0	0.0
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ		
Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх НМТ	1252.0	85850.0
3 хүртэл насны ихэр хүүхдэд жилд 1 удаа	2	240.0
Байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд нэг удаа	1196	70170.0
3 ба түүнээс дээш тооны хүүхэдтэй өрх толгойлсон эх эцэгт олгосонӨрх толгойлсон	43	5040.0
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон иргэнд олгосон	7	7000.0
Гэнэтийн аюулын улмаас орон гэргүй болсон өрх	4	3400.0
Ахмад настанд нийгмийн хамгаалалын тухай хуулийн дагуу олгогдож байгаа 1 удаагийн хөнгөлөлт тусламж	4179	57465.5
ХБИргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт тусламж	137	27396.5
Хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн улсын төсвийн санхүүжилтийн гүйцэтгэл	8688	1457342.4
Хүүхдийн мөнгөн тэтгэмж		
Шинээр төрсөн хүүхдийн мөнгөн тусламж		
Шинэ гэр бүлд олгосон мөнгөн тусламж		
Жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж		233902.4
Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж	8646	1210220.0
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламж	42	13220.0
МУ-ын болон Хөдөлмөрийн баатар,ардын ба гавьяат цолтнуудад олгосон нэмэгдэл		
Маягт хэвлүүлсэн зардал		
Эхийн алдар одонгийн шагнал	0	
Банкны шимтгэл		1100.0
Бусад		

Нийгмийн халамжийн хэлтсийн мэдээг үндэслэв.

ХӨДӨӨ АЖ АХУЙ
AGRICULTURE

МАЛ ТӨЛЛӨЛТ, малын төрлөөр
FEMALE BREEDING STOCK GIVING BIRTH, by type of livestock

Малын төрөл	Type of livestock	Төллөсөн хээлтэгч, мян.тол Number of breeding stock, thous.heads			Төллөлтийн хувь Percentage of births to total breeding stock		
		2011 I-II	2012 I-II	2013 I-II	2011 I-II	2012 I-II	2013 I-II
Бүгд	<i>Total</i>	4112	12684	11011	0.4	1.3	0.9
Ингэ	<i>Female camel</i>		25	8		0.4	0.1
Гүү	<i>Mare</i>			1			0.002
Үнээ	<i>Cow</i>		48	88		0.1	0.2
Эм хонь	<i>Ewe</i>	3214	7539	6116	0.8	1.7	1.1
Эм ямаа	<i>Female goat</i>	898	5072	4798	0.2	1.1	0.9

МАЛ ТӨЛЛӨЛТ, сумаар
FEMALE BREEDING STOCK GIVING BIRTH, by soums

Сумдууд by soums	Төллөсөн хээлтэгч, мян.тол Number of breeding stock, thous.heads			Төллөлтийн хувь Percentage of births to total breeding stock		
	2011 I-II	2012 I-II	2013 I-II	2011 I-II	2012 I-II	2013 I-II
Дүн/ Total	4112	12684	11011	0.4	1.3	0.9
Баян-Өндөр						
Бүрд						
Бат-Өлзий						
ББ-Улаан		2324	1284		5.1	2.5
Баянгол		2229	1720		4.2	2.5
Гучин-Ус	1767		165	4.6		0.4
Есөнзүйл						
Өлзийт		184	585		0.4	1.1
ЗБ-Улаан	252	218		0.9	0.7	
Богд	1234	524	1342	1.5	0.7	1.5
Нарийнтээл						
Сант	107	2476	972	0.3	6.8	2.0
Тарагт		61	232		0.2	0.5
Төгрөг		2987	2801		13.7	9.5
Уянга		40	177		0.1	0.2
Хайрхандулаан		660	56		1.2	0.1
Хужирт						
Хархорин			976			1.3
Арвайхээр	752	981	701	2.6	2.9	1.3

ТӨЛ БОЙЖИЛТ, малын төрлөөр

SURVIVALS OF YOUNG ANIMALS, by type of livestock

Малын төрөл	Type of livestock	Бойжуулсан төл, мян.тол Number of survivals, thous.heads			Бойжилтын хувь Percentage of survivals		
		2011 I-II	2012 I-II	2013 I-II	2011 I-II	2012 I-II	2013 I-II
Бүгд	<i>Total</i>	4085	12684	11011	99.0	100.0	100.0
Ботго	<i>Young camel</i>		25	8		100.0	100.0
Унага	<i>Foals</i>			1			100.0
Тугал	<i>Calves</i>		48	88		100.0	100.0
Хурга	<i>Lambs</i>	3200	7539	6116	99.3	99.9	100.0
Ишиг	<i>Kids</i>	885	5072	4798	97.9	100.0	100.0

ТӨЛ БОЙЖИЛТ, сумаар

SURVIVALS OF YOUNG ANIMALS, by soums

Сумдууд by soums	Бойжуулсан төл, мян.тол Number of survivals, thous.heads			Бойжилтын хувь Percentage of survivals		
	2011 I-II	2012 I-II	2013 I-II	2011 I-II	2012 I-II	2013 I-II

Дүн/ Total 4085 12684 11011 99.0 100.0 100.0

Баян-Өндөр

Бүрд

Бат-Өлзий

ББ-Улаан 2324 1284 100.0 100.0

Баянгол 2229 1720 100.0 100.0

Гучин-Ус 1752 165 99.2 100.0

Есөнзүйл

Өлзийт 184 585 100.0 100.0

ЗБ-Улаан 256 218 96.6 100.0

Богд 1227 524 1342 99.4 100.0 100.0

Нарийнтээл

Сант 106 2476 972 99.1 100.0 100.0

Тарагт 61 232 100.0 100.0

Төгрөг 2987 2801 99.8 100.0

Уянга 40 177 100.0 100.0

Хайрхандулаан 660 56 100.0 100.0

Хужирт

Хархорин 976 100.0

Арвайхээр 744 981 701 98.9 100.0 100.0

ЗҮЙ БУС ХОРОГДСОН ТОМ МАЛЫН ТОО, малын төрлөөр
 NATURAL LOSSES OF ADULT ANIMALS, by type of livestock

Малын төрөл	Type of livestock	Хорогдсон мал, мян.тол			Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь		
		Number of losses of adult animals, thous.heads			Percentage of losses of adult animals to total livestock at the beginning of year		
		2011 I-II	2012 I-II	2013 I-II	2011 I-II	2012 I-II	2013 I-II
Бүгд	Total	7652	445	4865	0.4	0.02	0.16
Тэмээ	Camel	1	0	1	0.01		0.01
Адуу	Horse	229	21	266	0.2	0.01	0.2
Үхэр	Cattle	237	20	328	0.3	0.02	0.3
Хонь	Sheep	3699	179	1913	0.4	0.02	0.1
Ямаа	Goat	3486	225	2357	0.4	0.02	0.2

ЗҮЙ БУС ХОРОГДСОН ТОМ МАЛЫН ТОО, сумаар
 NATURAL LOSSES OF ADULT ANIMALS, by soums

Сумдууд by soums	Хорогдсон том мал, мян.тол			Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь		
	Number of losses of adult animals, thous.heads			Percentage of losses of adult animals to total livestock at the beginning of year		
	2011 I-II	2012 I-II	2013 I-II	2011 I-II	2012 I-II	2013 I-II
Дүн / Total	7652	445	4865	0.4	0.0	0.2
Баян-Өндөр	127	0	0	0.08		
Бүрд	1751	0	0	0.96		
Бат-Өлзий		0	1023			0.75
ББ-Улаан	108	43	337	0.10	0.04	0.25
Баянгол		0	0			
Гучин-Ус	815	0	196	0.95		0.16
Есөнзүйл	712	0	60	0.77		0.05
Өлзийт	618	0	20	0.70		0.02
ЗБ-Улаан	271	48	627	0.44	0.06	0.63
Богд	0	0	0			
Нарийнтээл	257	55	173	0.18	0.04	0.10
Сант		0	0			
Тарагт	736	9	201	1.33	0.01	0.18
Төгрөг	16	2	1	0.04		
Уянга	366	0	175	0.29		0.09
Хайрхандулаан	285	0	126	0.23		0.07
Хужирт		98	1011		0.08	0.70
Хархорин	1504	189	913	0.98	0.12	0.48
Арвайхээр	86	1	2	0.16		

ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, сумаар

LOSSES OF ANIMALS DUE TO THE DISEASES, by soums

Сумдууд by soums	Өвчнөөр хорогдсон мал, мян.тол Losses of animals due to the diseases, thous.heads			Зүй бус хорогдолд өвчний хорогдлын эзлэх хувь Percentage of losses due to diseases to total losses of animals		
	2011 I-II	2012 I-II	2013 I-II	2011 I-II	2012 I-II	2013 I-II
Дүн/ Total	77	0	10	1.0	0.0	0.2
Баян-Өндөр						
Бүрд						
Бат-Өлзий						
ББ-Улаан						
Баянгол						
Гучин-Ус						
Есөнзүйл						
Өлзийт	77			12.5		
ЗБ-Улаан						
Богд						
Нарийнтээл						
Сант						
Тарагт						
Төгрөг						
Уянга						
Хайрхандулаан						
Хужирт						
Хархорин			10			1.1
Арвайхээр						

ХЭЭЛТЭГЧИЙН ХОРОГДОЛ, сумаар

LOSSES ANIMALS DUE TO THE FEMALE ANIMALS, by soums

Сумдууд by soums	Хорогдсон хээлтэгч мал, тол Losses of female animals, heads			Зүй бус хорогдолд хээлтэгчийн эзлэх хувь, Percentage of losses due to female animals to total losses of animals		
	2011 I-II	2012 I-II	2013 I-II	2011 I-II	2012 I-II	2013 I-II
Дүн/ Total	698	46	971	9.1	10.3	20.0
Баян-Өндөр	25			19.7		
Бүрд						
Бат-Өлзий			288			28.2
ББ-Улаан	2	15	62	1.9	34.9	18.4
Баянгол						
Гучин-Ус	62		28	7.6		14.3
Есөнзүйл	91			12.8		
Өлзийт	84		10	13.6		50.0
ЗБ-Улаан			192			30.6
Богд						
Нарийнтээл	10		16	3.9		9.2
Сант						
Тарагт	201	4	84	27.3	44.4	41.8
Төгрөг						
Уянга	107		68	29.2		38.9
Хайрхандулаан	8		5	2.8		4.0
Хужирт		18	217		18.4	21.5
Хархорин	108	9	1	7.2	4.8	0.1
Арвайхээр						

ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ,
сараар

AVERAGE MARKET PRICE OF SOME AGRICULTURAL PRODUCTS, by months

Бүтээгдэхүүний нэр төрөл	name of product	Хэмжих нэгж, Measurement unit	2012- II /Урд оны мөн үед/	2012-XII /Жилийн эцэст/	2013-I /Өмнөх сард	2013-II /Тайлант сард/
1. Ноос, ноолуур, хөөвөр, хялгас	Wool, cashmere					
Тэмээний ноос	Camel's wool					
-эр ноос	Coarse wool	кг				
-эм ноос	Fine wool	кг				
Ямааны ноолуур	Greezy cashmere	кг	47,000	49,000	50,000	50,000
Үхрийн хөөвөр	cattle wool	кг	-	-	-	-
Адууны дэл	horse fuzz	кг	-	-	-	-
Адууны сүүл	horse tail	кг	-	-	-	-
2. Арьс, шир	Hide					
Тэмээний шир	camel hide	ш	-	18,000	18,000	20,000
Адууны шир	Horse hide	ш	40,000	40,000	41,000	35,000
Үхрийн шир	Cattle hide					
-2 метрээс доош хэмжээтэй шир	Less than 2m	ш		25,000	25,000	28,000
-2 метрээс дээш хэмжээтэй шир	More than 2m	ш	30,000	35,000	35,000	40,000
Хонины нэхий	Sheep skin	ш	11,000	9,000	8,000	6,000
Ямааны арьс	Goat skin	ш	23,000	24,000	24,500	25,000
3. Боодолтой өвс, 25 кг	hay, 25 kg	боодол	-	-	-	-

АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, оны үнээр, мян.төг

2013.03.05

Аж үйлдвэрийн салбар	2012	2013	Дүнд эзлэх хувь	
			2012	2013
Нийт дүн	1634082.2	1872106.6	96.5	100.0
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	343598.6	353545.0	21.0	18.9
Нүүрс олборлолт	343598.6	353545.0	21.0	18.9
Боловсруулах аж үйлдвэр	718498.0	922751.4	44.0	49.3
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дүн	535361.6	650035.1	32.8	34.7
Үүнээс:сүү, сүүн бүтээгдэхүүн	19346.7	31999.3	1.2	1.7
Талх, нарийн боов	271257.9	347696.2	16.6	18.6
Ундаа, ус, архи	228183.8	192242.9	14.0	10.3
Хиам	6110.0	10083.1	0.4	0.5
Хэрчсэн гурил, бууз, банш, бусад	9454.0	14535.3	0.7	0.8
Гурил	1009.2	0.0	0.1	-
Оёдол	39837.5	53478.3	2.4	2.9
Гутал	26930.0	62451.0	1.6	3.3
Мод, модон эдлэл тавилга	97256.8	68120.0	6.0	3.6
Хэвлэх	2282.1	8741.2	0.1	0.5
Нүдний шил	3590.0	2075.7	0.2	0.1
Бусад	13240.0	77850.1	0.8	4.2
Цахилгаан ,дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	571985.6	595810.2	35.0	31.8
Цахилгаан, дулаан	514550.0	538230.4	31.5	28.7
Ус ариутгал, усан хангамж	57435.6	57579.8	3.5	3.1

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, оны үнээр, мян. төг

2013.03.05

Аж үйлдвэрийн салбар	2012	2013	2013/2012 %
Нийт дүн	1722060.3	1955121.7	113.5
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	343598.6	353545.0	102.9
Нүүрс олборлолт	343598.6	353545.0	102.9
Боловсруулах аж үйлдвэр	806476.1	1005766.5	124.7
Хүнсний бүтээгдэхүүн	613130.8	639336.6	104.3
Оёдол	39837.5	56805.6	142.6
Гутал	28907.5	67978.6	1.4 дахин
Мод, модон эдлэл тавилга	104006.8	150130.0	144.3
Хэвлэх	3763.5	7492.5	199.2
Нүдний шил	3590.0	2075.7	57.8
Бусад	13240.0	81947.5	5.2 дахин
Цахилгаан ,дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	571985.6	595810.2	104.2
Цахилгаан, дулаан,	514550.0	538230.4	104.6
Ус ариутгал, усан хангамж	57435.6	57579.8	100.3

Тайлбар: Эрчим хүчний үйлдвэрийн мэдээ дүнд ороогүй болно.

ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2012	2013
Дулаан	мян г.кл	15.2	15.7
Цэвэр ус, сувагжуулалт	мян.м3	51.8	52.8
Нүүрс	мян.т	17.2	17.7
Гэрийн мод	ком	177	206
Гутал	хос	592	892
Гурил	тн	2.1	-
Талх	тн	92.1	92.4
Нарийн боов, бялуу	тн	134.7	146.6
Цэвэр ус, ундаа, жүүс	мян.л	225.6	196.7
Хэрчсэн гурил, бууз, банш	тн	8.5	10.9
Архи	мян.л	13.2	7.2
Сүү,тараг ,ааруул	тн	15.8	27.2
Даршилсан ногоо	тн	0.5	0.4
Хиам	тн	1.4	2.4

ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**2013.03.05**

Тээврийн төрөл, үзүүлэлтүүд	2012 1-2	2013 1-2	2013/2012 %
Авто замын тээвэр			
Тээсэн ачаа, мян. т	2.7	3.0	111.1
Ачаа эргэлт ,мян. т км	621.4	702.2	113.0
Зорчигчдын тоо, мян. хүн. км	25.1	29.8	118.7
Зорчигч эргэлт, мян. хүн км	5522.0	6820.4	123.5
Тээврийн орлого, мян.төг / оны үнээр /	162574.1	200811.3	123.5

ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**2013.03.05**

Үзүүлэлтүүд	2012	2013	2013/2012 %
Тарифын орлого, мян. төг	50757.9	51200.0	100.9
Үүнээс: Хүн амаас орсон орлого	8569.4	15100.0	176.2
Ажиллагсад	36	34	94.4
Телефон цэгийн тоо	1039	1019	98.1

ШИНЭЭР БИЙ БОЛСОН АЖЛЫН БАЙР

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар	2012	2013
Бүгд	50	166
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас агнуур	10	20
Уул уурхай, олборлох үйлдвэр	4	0
Боловсруулах үйлдвэр	4	5
Цахилгаан дулааны үйлдвэрлэл, усан хангамж	0	1
Барилга	1	70
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн бараа засварлах үйлчилгээ	11	5
Зочид буудал, зоогийн газар	0	17
Тээвэр, агуулахын аж ахуйн холбоо	0	1
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	8	5
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	0	0
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	10	29
Боловсрол	0	1
Эрүүл мэнд, нийгмийн халамж	0	0
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	2	12

ХХҮХ-ийн мэдээг үндэслэв

ШИНЭЭР БИЙ БОЛСОН АЖЛЫН БАЙР, сумаар

Сумын нэр	Бүгд	Үүнээс: Эмэгтэй
Баян-Өндөр	0	0
Бүрд	0	0
Бат-Өлзий	27	20
ББ-Улаан	0	0
Баянгол	0	0
Гучин-Ус	0	0
Есөнзүйл	0	0
Өлзийт	0	0
ЗБ-Улаан	0	0
Богд	0	0
Нарийнтээл	0	0
Сант	0	0
Тарагт	0	0
Төгрөг	0	0
Уянга	0	0
Хайрхандулаан	0	0
Хужирт	0	0
Хархорин	0	0
Арвайхээр	14	6
Бүгд	41	26

АЖИЛГҮЙЧҮҮДИЙН МЭДЭЭ

3/6/2013

Сумд	Бүртгэлтэй ажилгүйдүүд	Бүгдээс:Боловсролоор						
		Дээд	Тусгай дунд ийн	анхан шатны	Бүрэн дунд	Бүрэн бус дунд	Бага	Боловсро лгүй
Баян-Өндөр	98	18	6	3	25	35	10	1
Бүрд	25	3	2	2	6	7	5	0
Батэлзий	105	11	9	8	43	18	13	3
ББ-Улаан	23	4	3	3	5	5	3	0
Баянгол	21	0	2	4	6	4	4	1
Гучин-Ус	32	5	2	5	8	6	5	1
Есөнзүйл	30	6	3	3	7	7	3	1
Өлзийт	45	8	6	4	17	6	3	1
ЗБ-Улаан	62	11	4	5	19	12	9	2
Богд	40	5	3	4	13	8	6	1
Нарийнтээл	30	7	4	2	10	5	2	0
Сант	39	10	3	2	13	8	3	0
Тарагт	45	4	4	3	17	9	7	1
Төгрөг	30	5	4	3	11	4	3	0
Уянга	40	7	5	4	12	8	3	1
Хайрхандулаан	58	9	8	3	21	13	3	1
Хужирт	68	7	8	7	16	17	12	1
Хархорин	206	67	4	6	32	71	23	3
Арвайхээр	601	134	23	13	277	98	45	11
ДҮН	1598	321	103	84	558	341	162	29

АЖИЛГҮЙДЛИЙН МЭДЭЭ

	Бүгд	Үүнээс: Эмэгтэй
1. Өмнөх сарын эцэст байсан ажилгүйдүүд	1598	911
2. Тайлант сард нэмэгдсэн ажилгүйдүүд	494	259
Үүнээс : Орон тооны цомхтголоос	0	0
Байгууллага татан буугдсанаас	0	0
Өөр газраас шилжиж ирсэн	2	2
Сургууль төгссөн	0	0
Цэргээс халагдсан		
Мэргэжлийн ажил олдохгүйгээс		
Цалин багатайгаас		
Бусад	116	60
3. Ажилгүйдүүдээс тайлант сард ажилд орсон	338	146
Үүнээс : Улсын үйлдвэрийн газар	0	0
Төрийн болон төсөвт байгууллага	13	10
Нөхөрлөл, компани	4	1
Хоршоо	0	0
Бусад	0	0
4. Тайлант сард ажилгүйдүүдийн бүртгэлээс хасагдсан	31	16
5. Тайлант сарын эцэст байгаа ажилгүйдүүд	1598	911
6. Тайлант сарын эцэст байгаа ажилгүйдүүд насны бүлгээр		
16-24	389	198
25-34	802	467
35-44	213	158
45-60	194	88

ХЭАлбаны мэдээг үндэслэв.

ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС
CONSUMER PRICE INDEX OF CERTAIN GOODS AND SERVICES

Үзүүлэлтүүд	Indicators	2013.02/2010.12	2012.02/2013.02	2012.12/2013.02	2013.01/2013.02
Хүнсний бараа, ундаа ус	<i>Food and non-alcoholic beverages</i>	117.7	100.6	104.3	99.7
Согтууруулах ундаа тамхи	<i>Alcoholic beverages tobacco</i>	178.7	163.7	100.0	100
Гутал хувцас,бөс бараа	<i>Clothing footwear and cloth</i>	131.6	120.4	102.8	102.1
Орон сууц, ус цахилгаан түлш	<i>Housing water electricity and fuels</i>	116.0	106.6	100.4	100.4
Гэр ахуйн бараа	<i>Furnishings household equipment and tools</i>	116.9	106.0	101.3	101.2
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	<i>Health medical care and services</i>	95.2	94.7	100.0	100
Тээвэр	<i>Transport</i>	124.2	104.5	102.2	100
Холбооны хэрэгсэл,шуудангийн үйлчилгээ	<i>Communication</i>	99.7	99.7	100.0	100
Амралт чөлөөт цаг соёлын бараа үйлчилгээ	<i>Recreation and culture</i>	110.2	104.5	100.0	100
Боловсролын үйлчилгээ	<i>Education</i>	123.3	109.9	100.0	100
Бусад бараа үйлчилгээ	<i>Miscellaneous goods and services</i>	108.7	105.2	102.6	102
ЕРӨНХИЙ ИНДЕКС	Index	121.6	108.2	102.4	100.6

Худалдаа, нийтийн хоолны бараа гүйлгээ /мян. төгрөг/

Үзүүлэлт	2012 он		2013 он	
	цэгийн тоо	бараа гүйлгээний орлого	цэгийн тоо	бараа гүйлгээний орлого
Барааны дэлгүүр	199	261469.0	224	368758.0
Хүнсний дэлгүүр	416	1387405.0	439	1768110.0
Үүнээс: согтууруулах ундааны гүйлгээ	293	687125.0	299	999080.0
Авто сэлбэгийн дэлгүүр	98	179710.0	100	222570.0
Барилгын материалын дэлгүүр	16	33960.0	17	66560.0
Ресторан бар	36	187450.3	36	196300.0
Цайны газар	68	85062	69	95492.4
ТҮЦ	15	8150.2	17	13990.0
Контейнер	254	196300.0	256	292400.0
Авто засварын газар	23	142757.0	26	178520.0
Шатахууны борлуулалт	53	3367977.0	57	3956026.4
Эм борлуулалт	35	155031.5	42	201650.0
ДҮН	1,213	6,005,272.0	1,283	7,360,376.8

ЭРҮҮЛ МЭНД
HEALTH

. ТӨРӨЛТ, ЭХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙН ТОО

Хугацаа <i>Periods</i>	Амаржсан эх <i>Number of mothers delivered</i>	Амьд төрсөн хүүхэд <i>Live births</i>	Төрөхийн улмаас эндсэн эх <i>Maternal deaths</i>	1хүртэл насандаа эндсэн хүүхэд <i>Infant deaths under age of 1 year</i>	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд <i>Infant deaths at age of 1-5 years</i>
2011	368	369	0	11	1
2012	405	408	0	13	0
2013	433	435	0	8	1

. ТӨРӨЛТ, ЭХ ХҮҮХЭДИЙН ЭНДЭГДЛИЙН ТОО,сумдаар
NUMBER OF BIRTHS,MATERNAL AND INFANT DEATHS,by soums

Сум	Амаржсан эх <i>Number of mothers delivered</i>	Амьд төрсөн хүүхэд <i>Live births</i>	Төрөхийн улмаас эндсэн эх <i>Maternal deaths</i>	1хүртэл насандаа эндсэн хүүхэд <i>Infant deaths under age of 1 year</i>	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд <i>Infant deaths at age of 1-5 years</i>
ББ-Улаан	1	1		1	
Бат-Өлзий	21	22			
Баянгол	2	2			
Баян-Өндөр	2	2			
Богд	12	12			
Бүрд	5	5			
Гучин-Ус	2	2		1	
Есөнзүйл	1	1			
ЗБ-Улаан	8	8			
Нарийнтээл	6	6			
Өлзийт	0	0			
Сант	7	7			
Тарагт	3	3			
Төгрөг	2	2			
Уянга	23	23			
Хайрхандулаан	5	5			
Хархорин	36	36		1	
Хужирт	12	12		1	
Арвайхээр	285	286		4	1
Дүн Total	433	435	0	8	1

ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО
NUMBER OF INFECTIOUS DISEASE CASES

Хугацаа Periods	Халдварт өвчнөөр өвчлөгчид-бүгд Infectious disease cases-total	үүнээс								
		Вируст гепатит Viral hepatitis	Цусан суулга Dysentery	Бруцеллёз Brucellosis	Зар Gonorrhoea	Тэмбүү Syphilis	Трихоминиаз Trichomoniasis	Сүрьеэ Tuberculosis	Гахай хавдар	Салхин цэцэг
2011	248	135	1	0	14	21	13	10	0	54
2012	223	149	0	0	6	10	12	14	14	15
2013	422	57	1	0	6	18	1	17	289	30

ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД, сумдаар
INFECTIOUS DISEASE, by soums

Сумд	Халдварт өвчнөөр өвчлөгчид-бүгд Infectious disease cases-total			үүнээс									
				Вируст гепатит hepatitis	Цусан суулга Dysentery	Бруцеллөз Brucellosis	Зар Gonorrhoea	Тэмбүү Syphilis	Трихоминиаз Trichomoniasis	Сүрьеэ Tuberculosis	Салхин цэцэг	Гахайн хавдар	
	2011	2012	2013										
ББаян-Улаан	0	0	2	1					1				
Бат-Өлзий	2	8	2						2				
Баянгол	3	8	6	1									5
Баян-Өндөр	4	0	13						1	1	11		
Богд	3	17	1	1									
Бүрд	0	1	0										
Гучин-Ус	11	4	3						1				
Есөнзүйл	1	2	0										
ЗБ-Улаан	1	0	1									1	
Нарийнтээл	11	15	1	1									
Өлзийт	1	0	0	0									
Сант	3	1	9	9									
Тарагт	0	10	6	1	1			1	1			2	
Төгрөг	2	2	5	3	1								1
Уянга	28	5	5	1	2			2					
Хайрхандулаан	2	19	6	0	1			4				1	
Хархорин	2	2	32	6						1	2	23	
Хужирт	2	10	22	11									11
Арвайхээр	61	46	308	24	1	3		13	9		12	243	
Дүн Total	137	150	422	57	1	0	6	18	1	17	30	289	

Х.1 БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО, төрлөөр
NUMBER OF OFFENCES COMMITTED, by soums

3/6/2013

Хэргийн төрөл	2011	2012	2013	Type of offences
Бүртгэгдсэн хэрэг- Бүгд	78	110	102	Offences-Total
-Бусдын амийг хорлосон	1	0	2	-Man slaughter
-Хүчингийн хэрэг	3	1	1	-Rape
-Танхайн хэрэг	3	2	5	-Indecent assault
-Хулгай	26	39	28	-Theft
-Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг хэрэг	4	12	5	-Crimes against safety of traffic movement
-Иргэний эрүүл мэндийн эсрэг хэрэг	23	40	31	-Offences against the health of individuals
-Бусад	16	13	30	Other
Гэмт хэргийн улмаас учирсан хохирол Total amount of damage caused by offences				
Гэмтэж бэртсэн хүн	22	41	31	Number of injured people
Нас барсан хүн	12	22		Number of died people
Нийт хохирол/сая.төг/	45.8	63.1	87.5	Total amount of damage /mln.tog/
Нөхөн төлүүлсэн/сая.төг/	8.7	31.5	60.6	Peimbursed /mln.tog/

Х.3 БҮРТГЭСЭН ХЭРЭГТ ХОЛБОГДСОН СЭЖИГТЭН,ЯЛЛАГДАГЧДЫН ТОО
NUMBER OF
OFFENDERS

Хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчид	2011	2012	2013	Number of offenders
Бүгд	61	101	77	Total
Хэрэг үйлдэхдээ:				Crime committed by:
-Бүлэглэсэн	22	41	19	-Group of people
-Согтуу байсан	20	48	29	-Drunk people
Эрүүлжүүлэгдсэн хүн	285	242	256	Number of restored

Х.2. БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО,сумдаар
NUMBER OF OFFENCES COMMITTED,by soums

Сумд	2011	2012	2013	Soums
Баян-Өндөр	2	3	1	<i>Bayan-Under</i>
Бүрд	2	7	4	<i>Burd</i>
Баянгол	2	1	2	<i>Bayangol</i>
Бат-Өлзий	3	9	5	<i>Bat-Ulzii</i>
ББ-Улаан	1		2	<i>BB-Ulaan</i>
Гучин-Ус		2	3	<i>Guchin-Us</i>
Есөнзүйл	1	1		<i>Esenzuil</i>
Өлзийт				<i>Ulziit</i>
ЗБ-Улаан	2	2	4	<i>ZB-Ulaan</i>
Богд	1	1	4	<i>Bogd</i>
Нарийнтээл	4	5	1	<i>Nariinteel</i>
Сант	1	3	1	<i>Sant</i>
Тарагт	2	7	3	<i>Taragt</i>
Төгрөг	1		1	<i>Tugrug</i>
Уянга	4	6	9	<i>Uyanga</i>
Хайрхандулаан	2	4	4	<i>Hairhandulaan</i>
Хужирт	3	4	6	<i>Hujirt</i>
Хархорин	19	14	11	<i>Harhorin</i>
Арвайхээр	28	41	41	<i>Arvaiheer</i>
Дүн	78	110	102	Total


I. АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГТ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлсээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас ихээхэн хамааралтай бөгөөд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний гол хэрэглээ, зарим боловсруулах үйлдвэрийн үйлдвэрлэлийн гол түүхий эд болдог.

2011 оны байдлаар манай аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) –ий 55.0 хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлж, 2012 оны жилийн эцэст нийт хөдөлмөрийн насны хүн амын 37.2 хувь, ажиллагсдын 55.1 хувь нь энэ салбарт ажиллаж байна.

Зураг 1.

ДНБ-нд ХАА-н салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь



Салбарын бүтцээр анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбар нь аймгийн ДНБ-ний 60.0-80.0 шахам хувийг эзэлсээр байсан ба 2000 оноос хойшхи хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшигаас үүдэн, мөн үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж хөдөө аж ахуйн салбарын ДНБ-нд эзлэх хувийн жин буурч, улмаар үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын эзлэх хувийн жин өссөөр байна.

Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, мөн мал аж ахуй болон газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй, баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болдог.

ТАНИЛЦУУЛГА

/Малын тоо, бүтэц,
2012 оны эцсийн

байдлаар/

II. МАЛ АЖ АХУЙ

II.1 МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ

Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 98.6 тэрбум төгрөг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 40.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхтой харьцуулахад оны үнээр 19.4 хувиар зэрэгцүүлэх үнээр 12.0 хувиар өсч байна.

Хүснэгт 1.

Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

	2007	2008	2009	2010	2011	2012*	тэрбум төг	
							2012/2011	
							хувь	зөрүү
Тайлант оны үнээр	74.6	77.9	88.9	67.6	82.6	98.6	119.4	16.0
2005 оны зэрэгцүүлэх үнээр	51.7	58.8	83.9	42.3	35.9	40.2	112.0	4.3


* -Урьдчилсан гүйцэтгэлээр

Мал аж ахуйн салбарт 2012 онд нядалгааны жингээр 22.5 мян.тн мах, 30.7 мян.тн сүү, 1.4 мян.тн хонины ноос, 0.4 мян.тн ямааны ноолуур, 0.05 мян.тн тэмээний ноос, 37.2 мян.тн хөөвөр, хялгас, 421.6 мянган ширхэг арьс шир үйлдвэрлэв.

Өмнөх онтой харьцуулахад махны үйлдвэрлэл, нядалгааны жингээр 2.1 мян.тн, сүүний үйлдвэрлэл 5.6 мян.л, хонины ноос 0.5 мян.тн, ямааны ноолуур 0.1 мян.тн, тэмээний ноос 3.9 тн, бодын хөөвөр, хялгас 18.4 тн-оор, арьс шир 48.3 мянган ширхэгээр тус тус өссөн байна.

Зураг 2.

Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, бууралт



Хүснэгт 2.

Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, биет хэмжээгээр

	2008	2009	2010	2011	2012*	2012/2011	
						хувь	зөрүү
Мах, нядалгааны жингээр, тн	26824.9	38023.9	22198.4	20324.7	22463.8	110.5	2139.1
Тэмээний	352.8	308.8	511.5	365.7	362.1	99.0	-3.6
Адууны	4663.9	6485.8	4319.9	3718.9	4168.5	112.1	449.6
Үхрийн	5578.0	6408.0	4196.4	3546.8	3536.2	99.7	-10.6
Хонины	9563.7	13260.7	7616.7	7261.6	7448.5	102.6	186.9
Ямааны	6666.5	11560.6	5553.9	5431.7	6948.5	127.9	1516.8
Сүү, л	29902.5	35835.8	10919.7	24913.5	30659.9	123.1	5746.4
Ингэний	235.1	261.9	195.1	334.1	361.1	108.1	27.0
Гүүний	3608.0	4623.9	1203.0	3834.7	4759.9	124.1	925.2
Үнээний	16115.1	18958.3	6469.7	12329.2	15861.6	128.7	3532.4
Хонины	5048.5	6094.7	1760.5	3799.6	4573.0	120.4	773.4
Ямааны	4895.8	5897.0	1291.4	4615.9	5104.3	110.6	488.4
Ноос, ноолуур, тн	2108.4	2270.9	1525.9	1327.5	1571.1	118.4	243.6
Тэмээний ноос	44.7	46.6	50.0	48.5	52.4	108.0	3.9
Хонины ноос	1608.3	1726.1	1166.6	986.3	1156.9	117.3	170.6
Ямааны ноолуур	395.1	438.0	272.4	255.5	316.5	123.9	61.0
Бодын хөөвөр	20.5	20.4	12.5	12.6	15.4	122.2	2.8
Бодын хялгас	39.8	39.8	24.4	24.6	29.9	121.5	5.3
Арсь, шир, мян.ширхэг	459.8	751.9	1409.6	373.2	412.9	110.6	39.7
Тэмээний шир	1.2	1.1	2.1	1.2	1.2	100.0	0.0
Адууны шир	16.8	24.0	63.0	13.4	14.7	109.7	1.3
Үхрийн шир	21.1	25.6	68.3	13.6	13.8	101.5	0.2
Хонины нэхий	242.0	358.5	690.9	188.0	188.0	100.0	0.0
Ямааны нэхий	178.7	342.7	585.3	157.0	195.3	124.4	38.3

*-Урьдчилсан гүйцэтгэлээр

2012 онд нэг хүнд дунджаар 201.7 кг мах, 275.3 кг сүү ногдож, өмнөх онтой харьцуулахад мах 20.5 кг, сүү 53.2 л-ээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 3.

Нэг хүнд ногдох мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн

	2008	2009	2010	2011	2012**
Мах, нядалгааны жингээр, кг	243.9	343.5	199.0	181.2	201.7
Сүү, л	271.9	323.7	97.9	222.1	275.3

*-жилийн дундаж хүнд ногдуулж тооцсоноор

** -Урьдчилсан гүйцэтгэлээр

**II.2 МАЛ ТЭЖЭЭВЭР АМЬТАД, ХАШАА ХУДГИЙН 2012 ОНЫ
ТООЛЛОГЫН ДҮН**

Малтай өрх, малчдын тоо. 2012 онд мал бүхий 17272 өрх тоологдсон ба үүний 78.8 хувь нь буюу 13603 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж

байна. Хувийн малтай өрх аймгийн хэмжээний нийт өрхийн 53.9 хувийг эзэлж байна.

2012 онд мал аж ахуйн үйлдвэрлэлд 26687 малчид ажиллаж байна. Малчин өрхийн ам бүлийн тоо 49166 байгаа ба нэг малчин өрхийн ам бүлийн тоо дунджаар 3.6 байна. Малчдын 47.4 хувь нь буюу 12655 эмэгтэй малчид байна.

Насны бүлгээр нь авч үзвэл 42.9 хувь нь 16-34 насны, 47.1 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах насны, 10.1 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна.

Хүснэгт 4.

Өрх, малчдын тоо, насны бүтэц

	2008	2009	2010	2011	2012	2012/2011	
						хувь	зөрүү
Малтай өрх	20062	19888	17974	17211	17272	100.4	61
Малчин өрх	17015	16855	15536	14775	13603	92.1	-1172
Малчдын тоо	33985	32847	30771	28457	26687	93.8	-1770
Үүнээс:16-34 насны	16467	15344	13878	12412	11436	92.1	-976
35-аас тэтгэвэрт гарах насны	12608	12823	12554	12419	12560	101.1	141
Тэтгэврийн насны	4910	4680	4339	3626	2691	74.2	-935
Нийт малчдаас эмэгтэй	15968	15092	14133	13156	12655	96.2	-501
Насны бүтэц %	100	100	100	100.0	100.0	-	0.0
Үүнээс:16-34 насны	48.5	46.7	45.1	43.6	42.9	-	-0.8
35-аас тэтгэвэрт гарах насны	37.1	39	40.8	40.8	47.1	-	6.3
Тэтгэврийн насны	14.4	14.2	14.1	14.1	10.1	-	-4.0
Нэг малчин өрхөд ногдох малын тоо	203	215	129	164	218	169.0	89.0


2012 онд малтай өрхийн тоо 2011 онтой харьцуулахад 61-ээр нэмэгдэж, малчин өрх 1172-оор, малчдын тоо 1770-аар, эмэгтэй малчид 501-ээр тус тус буурсан байна.

Малчин өрхийн тоо Баян-Өндөр, Бат-Өлзий, Баруунбаян-Улаан, Баянгол, Гучин -Ус, Есөнзүйл, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Сант, Тарагт, Төгрөг, Уянга, Хайрхандулаан, Хужирт, Хархорин сумдад буурч, Бүрд, Богд, Арвайхээр сумдад өссөн байна.

2012 онд 1 малчин өрхөд 218 толгой мал ногдож байгаа нь 2011 оныхоос 54 толгойгоор өссөн байна.

Зураг 3.

Малчдын тоо, насны бүлгээр



Малчдын соёл, ахуйн үзүүлэлт. 2012 оны тооллогоор нийт малчин өрхийн 87.4 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 82.7 хувь нь телевизтэй, 25.1 хувь нь автомашинтай, 56.2 хувь нь мотоцикльтой, 0.4 хувь нь трактортой, 69.8 хувь нь малын хашаатай, 13.7 хувь нь худагтай байна.

Хүснэгт 5.

Малчдын соёл ахуйн үзүүлэлтүүд

	Өрхийн тоо						Малчин өрхийн тоонд эзлэх хувь					
	2007	2008	2009	2010	2011	2012	2007	2008	2009	2010	2011	2012
Цахилгаантай	10 042	11 560	12 285	11 892	12 396	11894	60.6	67.9	72.9	76.5	83.9	87.4
Телевизтэй	7 849	9 280	10 901	9 962	11 330	11253	47.4	54.5	64.7	64.1	76.7	82.7
Автомашинтай	2 469	2 875	3 070	3 247	3 530	3412	14.9	16.9	18.2	20.9	23.8	25.1
Мотоцикльтой	6 281	7 036	7 300	7 583	7 905	7645	37.9	41.4	43.3	48.8	53.5	56.2
Трактортай	54	44	66	45	37	60	0.3	0.3	0.4	0.3	0.3	0.4

Сүүлийн жилүүдэд хөдөө орон нутагт нарны зайн цахилгаан эх үүсгүүрийн хэрэглээ нэмэгдэж, тэр хэмжээгээр бусад үзүүлэлтүүд тухайлбал телевизортой өрхийн тоо өссөөр байгаа. 2012 оны хувьд малчин өрхийн тоо буурсантай холбогдон 2011 оныхоос цахилгаан эх үүсгүүртэй өрхийн тоо 502-оор буюу 4.0 хувиар, телевизтэй өрхийн тоо 77-оор буюу 1.0 хувиар, автомашинтай өрхийн тоо 118-аар буюу 3.3 хувиар, мотоцикльтэй өрхийн тоо

260-аар буюу 3.3 хувиар тус тус буурсан боловч малчин өрхийн тоонд эзлэх хувь байнга өссөөр байна.

2011 онд эдгээр үзүүлэлтүүд эргээд өссөн байна. Харин автомашинтай болон мотоцикльтой өрхийн тоо тасралтгүй өссөөр байна. Авто машинтай өрхийн тоо 283-аар буюу 8.7 хувиар, мотоцикльтой өрхийн тоо 322-оор буюу 4.2 хувиар тус тус өссөн, трактортой өрхийн тоо 2011 онд урд оноос 8-аар буурсан байна.

Зураг 4.



Малын тоо. 2012 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 2970.7 мянга болж, 2011 оныхоос 545.1 мянгаар буюу 22.5 хувиар өсчээ. 2012 онд малын тоо нь 5 төрөл дээрээ өссөн дүнтэй гарсан байна. Малын тооны өсөлт, бууралтыг сумчилж харвал Зүүнбаян-Улаан суманд тэмээ 2 толгойгоор, Хужирт суманд 8 толгойгоор буурч, бусад бүх суманд малын толгой 5 төрөл дээрээ өссөн байна.

Тооллогын дүнгээр тэмээний тоо 18134 толгой, адуу 170536 толгой, үхэр 113966 толгой, хонь 1310889 толгой, ямаа 1357163 толгойд хүрч, 2011 оныхоос тэмээ 2261, адуу 29437, үхэр 23399, хонь 259135, ямаа 230807 толгойгоор тус тус өссөн үзүүлэлт гарсан байна.

2012 онд 932.0 мянган толгой төл бойжуулсан нь өмнөх оноос 111.6 мянгаар буюу 13.6 хувиар өсч, том малын зүй бус хорогдол 13.9 мянган толгойгоор буурсан байна. 2012 онд 52638 сарлаг тоологдсон нь нийт үхэр сүргийн 46.2 хувийг эзэлж байна. Сарлагийн тоо 2011 оныхоос 31.1 хувиар буюу 12472 толгойгоор өссөн байна.

Хүснэгт 6.

Малын тоо, төрлөөр

мян.толгой

	2007	2008	2009	2010	2011	2012	2012/2011	
							хувь	зөрүү
Бүгд	3 190.1	3 449.8	3 620.2	2 010.5	2 425.6	2970.7	122.5	545.1
Тэмээ	13.5	14.1	15.2	14.7	15.9	18.1	113.8	2.2
Адуу	174.9	173	183.4	113.8	141.1	170.5	120.8	29.4
Үхэр	133.5	134.8	141.1	76.2	90.5	113.9	125.9	23.4
Хонь	1 462.1	1 569.2	1 691.4	896.6	1 051.7	1310.9	124.6	259.2
Ямаа	1 406.1	1 558.7	1 589.1	909.2	1 126.4	1357.2	120.5	230.8

Манай оронд цас их орж, хүйтрэн өвөлжилт хүндэрч, гурван жил дараалан зуд үүрэлсэн жилүүд хамгийн сүүлд 1999-2001 онд мөн 2009-2010 онд шилжих өвөл тохиолдсон.


Хүснэгт 7.

Зудны дараах жилийн малын тооны өсөлт, төрлөөр

	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1999-2001 оны зудны жилийн дараах жилд						
2002	1 665.3	13.3	115.1	75.3	805.9	655.7
2003	1 918.8	13.9	123.8	83	881.7	816.4
2003/2002 %	115.2	104.5	107.6	110.2	109.4	124.5
Нийт өсөлтөд 5 төрлийн эзлэх хувь	100.0	0.2	3.4	3.0	29.9	63.4
2009-2010 оны зудны жилийн дараах жилд						
2010	2 010.5	14.7	113.8	76.2	896.6	909.2
2011	2 425.6	15.9	141.1	90.6	1 051.7	1 126.3
2011/2010 %	120.6	108.2	123.9	118.9	117.3	123.9
Нийт өсөлтөд 5 төрлийн эзлэх хувь	100.0	0.3	6.6	3.5	37.4	52.3

Зүй бус хорогдсон том малын тоо 1999-2001 онд 1158.5 мянган толгойд хүрч байсан бол 2009-2010 оны зудны жилд 1664.3 мянган толгой мал зүй бусаар хорогдсон. Зудны дараах жилийн малын тооны өсөлтийг хүснэгт 4 –өөс харвал 2002-2003 онд 15.2 хувиар өсч байсан бол 2010-2011 онд 20.6 хувь өссөн үзүүлэлт гарсан байна. Нийт өсөлтөд 5 төрлийн эзлэх хувийг авч үзвэл 2002 онд нийт өсөлтийн 63.4 хувийг ямаан сүргийн өсөлт хангаж байсан бол 2011 онд 52.3 хувь болж 11.1 пунктээр буурч, хонин сүргийн өсөлт 29.9 хувь байснаа 37.4 хувь болж 7.5 пунктээр өссөн нь эерэг үзүүлэлт юм.

Зураг 5.



2012 оны мал тооллогын дүнгээр өмнөх зудтай жилүүдтэй харьцуулахад 19 сумын малын тоо таван төрөл дээрээ 4.0-66.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 8.

Малын тооны өсөлт, бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүд

	2007	2008	2009	2010	2011	2012	2012/2011	
							хувь	зөрүү
Бойжуулсан төл	983.7	949.2	1 145.7	298.1	820.5	932.0	275.2	522.4
Том малын зүй								
бусын хорогдол	12.1	139.6	111.3	1 664.3	21.9	8.0	1.3	-1 642.4
Хээлтэгч малын тоо	1 251.8	1 397.7	1 434.2	933.3	968.9	1190.5	103.8	35.6
Хээл хаясан								
хээлтэгч	9.5	42.6	52.0	185.7	21.8	0.002	11.7	-163.9
Сувайрсан хээлтэгч	29.6	64.6	55.7	149.1	77.1	0.2	51.7	-72

Нийт малын тоо хамгийн өндөр нь өсөлттэй нь Арвайхээр сум 56.8 хувь, хамгийн бага өсөлттэй нь Нарийнтээл сум 9.1 хувийн өсөлттэй байна.

Хүснэгт 9.

2001 оноос хойшхи жилүүдийн малын тооны өсөлт, бууралт

	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Өссөн жилийн тоо	9	6	8	9	9	9
Буурсан жилийн тоо	2	5	3	2	2	2
2001 оноос өссөн хэмжээ, мян.тол	1101.6	3.4	29.5	14.7	399.8	654.2
2001 оноос буурсан хэмжээ, мян.тол	-	-	-	-	-	-

2001 оноос хойшхи 11 жилийн 9 жилд нь малын тоо өсч, 2 жилд нь буурчээ. Энэ хугацаанд малын тоо 2009 онд хамгийн өндөр буюу 3620.2 мянгад хүрч байсан ба 2001 онтой харьцуулахад 2012 онд нийт мал 1101.6 мянгаар өсч, малын төрлөөр авч үзвэл тэмээ 3.4, адуу 29.5, үхэр 14.7, хонины тоо 399.8 мянгаар, ямааны тоо 654.2 мянгаар тус тус өссөн байна.

2012 оны байдлаар нийт мал сүргийн 89.8 хувийг бог мал, 10.2 хувийг бод мал эзэлж байна. Энэ харьцаа 2011 онтой ижил түвшинд байна.

Харин нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийн жинг авч үзвэл урд оноос тэмээ, адуун сүрэг тус бүр 0.1 пунктээр буурсан, үхэр сүрэг 0.1 пунктээр, хонин сүргийн эзлэх жин 0.7 пунктээр өссөн, ямаан сүргийн эзлэх жин 0.7 пунктээр буурсан байна. Ямаан сүргийн эзлэх хувийн жин буурсан нь бага боловч эерэг үзүүлэлт юм.

Хүснэгт 10.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

	2007	2008	2009	2010	2011	2012
Бүгд	100	100	100	100	100	100
Тэмээ	0.4	0.4	0.5	0.7	0.7	0.6
Адуу	5.5	5.1	5.1	5.7	5.8	5.7
Үхэр	4.2	3.9	3.9	3.8	3.7	3.8
Хонь	45.8	45.5	46.7	44.6	43.4	44.1
Ямаа	44.1	45.1	43.8	45.2	46.4	45.7


Бог малын дотор хонь 75 хувь, ямаа 25.0 хувь байсан уламжлалт харьцаа сүүлийн жилүүдэд ихээхэн хэмжээгээр алдагдсаар байгаа буюу жил ирэх тусам ямааны эзлэх хувь нэмэгдсээр байгаа энэ харьцаа 2009 онд бага

зэрэг буюу 1.4 хувиар буурсан үзүүлэлт гарч байсан. 2010 оны зудтай жилд ч өссөн үзүүлэлт гарсан байна. Нийт сүрэгт ямаан сүргийн эзлэх хувь 2008 оны эцэст 45.1 хувь байсан бол 2009 онд 43.8 хувь болж 1.3 пунктээр буурч, 2010 онд 45.2 хувь болж 1.4 пунктээр, 2011 онд 46.4 хувь болж 1.2 пунктээр өссөн харин 2012 онд 0.7 пунктээр буурсан байна.

Ямаан сүргийн тооны өсөлт, бууралтыг ямаанаас гарах түүхий эд болох ноолуурын үнэтэй холбож харж болох талтай. (Хавсралт41.)

Сумдаар авч үзэхэд бог малынх нь 36.1-76.4 хүртлэх хувийг ямаан сүрэг эзэлж байна. Энэ нь ерөнхийдөө мал сүргийн бүтцэд зохисгүй өөрчлөлт гарч байгааг харуулж буй анхаарал татсан асуудал юм. Цаашид ямаан сүргийн тоо толгойн өсөлт үргэлжилбэл байгаль орчин, бэлчээрийн хүрэлцээнд ямар нөлөөтэйг тогтоож, сүргийн бүтцийн зохистой харьцааг тодорхойлж, энэ талаар мэргэжлийн байгууллагаас асуудал боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Зураг 6.




2012 онд Өвөрхангай аймагт нийт мал болон хонин сүргийн тоогоор Баян-Өндөр сум, тэмээ болон ямаан сүргийн тоогоор Богд сум, адуун сүргийн тоогоор Бүрд сум, үхэр сүргийн тоогоор Уянга сум тус тус тэргүүлж байна.

2012 оны эцэст тоологдсон малын дүнгээр Баян-Өндөр сум 256.2, Бүрд сум 244.0, Богд сум 242.9, Хархорин сум 192.0, Уянга сум 191.3 мянган толгой малаар тус тус тэргүүлж байна. Нийт 19 сумын 106 багаас малаараа тэргүүлж байгаа 5 багийг нэрлэвэл Баян-Өндөр сумын Батхаан баг 78.7, Бүрд сумын Ар жаргалант баг 69.1, Бүрд сумын Донгит баг 59.6, Нарийнтээл сумын Баянтээг

баг 59.4, Уянга сумын Жаргалант баг 56.3 мянган толгой малаар тус тус тэргүүлж байна.

Зураг 7.

Малын тоогоор тэргүүлсэн сумдууд



Хувийн /амины/ малын тоо. 2012 онд хувийн малын тоо 2967.9 мянган толгой тоологдож, нийт малын 99.9 хувийг эзэлж байна. Тэмээний 99.8 хувь, адууны 99.9 хувь, үхрийн 99.9 хувь, хонины 99.8 хувь, ямааны 99.9 хувь нь хувийн аж ахуйд байна. (Хавсралт 9.10)

Хувийн малын тоо 2011 оныхоос 544.5 мянгаар буюу 22.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 11.

Хувийн малтай өрх, малын тоо

Он	Малтай өрхийн тоо, мян.өрх	Бүгд	Үүнээс:				
			Мян.тол				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2000	23.4	2137.0	16.4	177.1	174.1	1043.5	725.9
2001	21.8	1854.2	14.7	140.5	99	900.3	699.7
2002	20.6	1655.8	13.3	114.8	75.2	799	653.5
2003	20.1	1910.8	13.9	123.6	82.9	876.5	813.9
2004	19.9	2148.4	13.8	132.8	91.1	966.6	944.1
2005	19.7	2294.3	13.1	136.4	99.6	1054.8	990.4
2006	19.3	2616.2	13	151	111	1208.7	1132.5
2007	20.0	3182.7	13.5	174.7	133.3	1457.1	1404.1
2008	20.1	3443.1	14.1	172.8	134.7	1564.7	1556.8
2009	19.9	3610.9	15.1	183.3	140.9	1684.5	1587.1
2010	18.0	2008.4	14.7	113.7	76.2	895.0	908.8
2011	17.2	2423.4	15.8	141.1	90.5	1 050.1	1 125.8
2012	17.3	2967.9	18.1	170.5	113.9	1308.8	1356.5

2012 оны байдлаар хувийн аж ахуйн нийт малын 45.7 хувийг ямаа, 44.1 хувийг хонь, 5.7 хувийг адуу, 3.8 хувийг үхэр, 0.6 хувийг тэмээ эзэлж байна.

2012 оны эцэс дэх иргэдийн хувийн малын бүлэглэлтээс авч үзвэл 2011 оныхоос бүх бүлгийн малтай өрхийн тоо өссөн дүн гарчээ.

2012 онд нийт малтай өрхөд 100 хүртэл толгой малтай өрхийн эзлэх хувийн жин 44.0 хувь болж, 2011 оныхоос 7.6 пунктээр буурсан, түүнээс дээшхи бүлгийн малтай өрхийн эзлэх хувийн жин 56.0 хувь болж, өмнөх оноос 7.6 пунктээр өссөн байна. 2012 оны байдлаар малтай өрхийн 44.0 хувь нь 100 хүртэл толгой малтай, 27.2 хувь нь 101-200 толгой малтай байна. Өөрөөр хэлбэл малтай нийт өрхийн 71.2 хувь нь 200 хүртэл толгой малтай байна. Энэ үзүүлэлт 2011 онд 78.2 хувь байлаа.

Хүснэгт 12.

Малтай өрхийн малын бүлэглэлт

	Малтай өрхийн тоо			Малчин өрхөд ногдох мал			Малын тоо, мян.тол		
	2010	2011	2012	2010	2011	2012	2010	2011	2012
Бүгд	17974	17211	17272	112	141	172	2008.4	2423.4	2967.9
100 хүртэлх малтай	11234	8877	7603	40	44	46	446.3	385.8	353.2
101-200 малтай	3832	4585	4692	139	143	145	531.5	654.1	679.5
201-500 малтай	2507	3141	4045	287	296	303	720.6	929.9	1225.5
501-999 малтай	319	498	755	644	634	648	205.3	315.5	489.6
1000-1499 малтай	70	93	156	1127	1123	1138	78.9	104.4	177.5
1500-2000 малтай	5	9	12	1600	1600	1692	8.0	14.4	20.3
2001 дээш малтай	7	8	9	2529	2413	2456	17.7	19.3	22.1

1000 ба түүнээс дээш малтай 156 өрх тоологдсон нь 2011 оныхоос 63 өрхөөр өссөн байна. 1000-аас дээш малтай өрхийн тоогоор Бүрд суманд 43 өрх, Баян-Өндөр суманд 29 өрх, Гучин-Ус суманд 14 өрх, Уянга суманд 11 өрх, Нарийнтээл суманд 10 өрх тоолуулж бусад сумдууд 10 дотор өрх тоолуулсан байна. Зүүнбаян-Улаан суманд 1000-с дээш малтай өрх тоологдоогүй байна.

Аймгийн дунджаар хувийн малтай нэг өрхөд 171 толгой мал ногдож байгаа нь 2011 оныхоос 31 толгой малаар өссөн байна. Малтай 1 өрхөд дунджаар тэмээ 1, адуу 10, үхэр 7, хонь 76, ямаа 78 ноогдож байна.

Малтай 1 өрхөд ногдох малын тоо, бүлэглэлтээр

	2010	2011	2012					
			Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
ДҮН	112	141	172	1	10	7	76	78
10 хүртэл малтай	5	5	6	0	0	2	1	3
11-30 малтай	20	20	21	0	2	1	7	11
31-50 малтай	40	40	41	0	2	2	15	22
51-100 малтай	73	74	74	0	4	4	28	38
101-200 малтай	138	142	145	0	9	7	58	71
201-500 малтай	288	295	303	2	17	10	132	142
501-999 малтай	643	634	649	6	34	18	330	261
1000-1499 малтай	1 129	1 123	1 138	12	69	39	623	395
1500-2000 малтай	1 605	1 599	1 693	1	123	47	1 188	334
2001 дээш малтай	2 534	2 409	2 455	6	114	90	1 702	543

Малтай нэг өрхөд ногдох малын тоо (толгойгоор) аймгийн 19 сумын хэмжээнд урд оноос өссөн үзүүлэлт гарсан ба 2012 оны хувьд Бүрд сум малтай нэг өрхөд ноогдох малын тоогоор тэргүүлж байна. Бүрд сумын малтай нэг өрхөд 334 толгой мал ноогдож байна. Малтай нэг өрхөд ноогдох амины малын тоо 172 байна.

2012 онд малчин нэг өрхөд ногдох малын тоо мөн 218 болж өмнөх оноос 54 толгойгоор өссөн байна.

Хээлтэгч мал. 2012 оны эцэст 1190.5 мянган толгой хээлтэгч мал тоологдсон нь 2011 оныхоос 221.6 мянган толгойгоор өссөн дотор ингэ 0.8 мянгаар, гүү 7.4 мянга, үнээ 7.3 мянга, хонь 109.7 мянга, ямаа 96.4 мянган толгойгоор тус тус өссөн байна.

Хээлтэгч малын тоо

	2007	2008	2009	2010	2011	2012	2012/2011	
							хувь	зөрүү
Бүгд	1 251.8	1 397.7	1 434.2	933.3	968.9	1190.5	122.9	221.6
Тэмээ	4.0	4.4	4.7	4.9	5.6	6.4	114.3	0.8
Адуу	47.7	48.4	51.3	35.9	42.0	49.4	117.6	7.4
Үхэр	46.5	49.0	49.0	30.2	34.6	41.9	121.1	7.3
Хонь	604.0	658.7	681.9	423.7	438.2	547.9	125.0	109.7
Ямаа	549.6	637.2	647.3	438.6	448.5	544.9	121.5	96.4

Хээлтэгч мал нийт малын 40.1 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 35.4 хувь, адуун сүргийн 29.0 хувь, үхэр сүргийн 37.0 хувь, хонин сүргийн 41.8 хувь, ямаан сүргийн 40.1 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 8.



Сумдаар авч үзвэл хээлтэгч малын тоо ингэ Есөнзүйл, Тарагт суманд тус бүр 2 толгойгоор буурч бусад сумдад 5 төрөл дээрээ өссөн дүн гарчээ.

2012 онд гарсан төлийн 96.2 хувийг буюу 932.0 мянган төл бойжуулав. Бойжсон төлийн тоо 2011 оныхоос 111.6 мянган толгойгоор буюу 10.9 хувиар өссөн байна. Гарсан ботгоны 100.0 хувь, унаганы 89.5 хувь, тугалны 90.5 хувь, хурганы 97.7 хувь, ишигний 96.3 хувийг бойжуулсан байна.

Бойжуулсан төл 2011 оныхоос таван төрөл дээр өссөн үзүүлэлт гарсан байна.

Хүснэгт 15.

Төл бойжилт								
	Бүгд			Үүнээс:				
	2010	2011	2012	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
	мян.тол							
Гарсан төл	577.7	841.0	940.9	3.2	38.2	31.7	431.7	436.1
Бойжсон төл	298.1	820.4	932.0	3.2	37.6	31.3	428.2	431.7
Бойжилтийн хувь	51.6	97.5	96.2	100.0	89.5	90.5	97.7	96.3

2012 онд төл бойжилт бүх сумдад тодорхой хувиар өссөн үзүүлэлт гарлаа.

Зураг 9.



Хүснэгт 16.

Бойжуулсан төл

	2007	2008	2009	2010	2011	2012
	МЯН.ТОЛ					
Бүгд	983.7	949.2	1145.7	298.0	820.4	932.0
Тэмээ	1.9	2.1	2.3	1.7	2.9	3.2
Адуу	34.5	28.5	36.5	9.5	30.3	37.6
Үхэр	35.2	31.8	37.5	12.8	24.4	31.3
Хонь	477.6	472.7	570.7	164.8	372.4	428.2
Ямаа	434.6	414.1	498.7	109.2	390.4	431.7

2012 онд аймгийн дунджаар 100 эхээс 96 төл бойжуулсан байна. 100 эхээс бойжуулсан төлийн тоо өмнөх оноос 8 толгойгоор өссөн байна.

Зураг 10.



100 эхээс бойжуулсан төл

	2007	2008	2009	2010	2011	2012
	МЯН.ТОЛ					
Бүгд	94	75.8	82.0	21.3	87.9	96.2
Тэмээ	49.1	51.4	52.3	39.0	59.8	56.7
Адуу	85.3	59.8	75.5	19.6	84.5	89.5
Үхэр	89.1	68.5	76.5	26.1	80.7	90.5
Хонь	95	78.3	86.6	25.0	87.9	97.7
Ямаа	94.4	75.3	78.3	17.1	89.0	96.3


Том малын зүй бус хорогдол. 2012 онд оны эхний малын 0.3 хувьтай тэнцэх 8.1 мянган толгой хорогдсон байна. Мал өвөлжилт, хаваржилт 2010 онд өмнөх жилүүдээс хүндэрч, 1664.3 мянган толгой том мал зүй бусаар хорогдоод байсан бол 2011 онд эрс буурч, 2012 онд 2011 оноос 3 дахин буурчээ. 2012 онд нийт хорогдсон малын 45.7 хувийг ямаа, 33.3 хувийг хонь, 4.9 хувийг адуу, 16.0 хувийг үхэр, 0.2 хувийг тэмээн сүрэг эзэлж байна.

Том малын зүй бусын хорогдол

	2007	2008	2009	2010	2011	2012
	МЯН.ТОЛ					
Бүгд	12.1	139.6	111.3	1664.3	21.9	8.1
Тэмээ	0	0	0.076	0.8	0.02	0.02
Адуу	1	15.5	2.5	80.1	0.9	0.4
Үхэр	1.1	10.9	3.3	79.4	0.9	1.3
Хонь	4.5	55.1	41.4	771.4	9.9	2.7
Ямаа	5.4	58	64	732.6	10.2	3.7

Том малын хорогдол Уянга суманд хамгийн өндөр буюу буюу 2.8 мянган толгой мал, Нарийнтээл, Тарагт сумдад 1.1-1.2 мянган толгой мал хорогдсон нь нийт аймгийн хэмжээний том малын хорогдлын 64.0 хувийг эзэлж байна. Бусад сумдын хорогдол 0.6 мянга хүртэл толгой буюу 36.0 хувийг эзэлж байна.

Том малын зүй бусын хорогдол



Оны эхний малд зүй бус хорогдлын эзлэх хувь

	2007	2008	2009	2010	2011	2012
Бүгд	0.5	4.0	3.2	46.0	0.6	0.2
Тэмээ	0.0	0.5	0.5	5.3	0.1	0.1
Адуу	0.0	9.0	1.4	43.7	0.5	0.3
Үхэр	0.0	8.1	2.5	56.3	0.6	1.4
Хонь	0.2	3.5	2.6	45.6	0.6	0.3
Ямаа	0.2	3.7	4.1	46.1	0.6	0.3

2012 онд нийт хорогдлын 11.8 хувь буюу 956 толгой мал гэнэтийн аюулаар, 2.7 хувь буюу 218 толгой нь өвчнөөр, 85.5 хувь буюу 6899 толгой нь бусад шалтгаанаар хорогджээ.

Гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо

	2007	2008	2009	2010	2011	2012
Бүгд	1 533	290	6 541	1 623 173	7 685	956
Тэмээ	10	0	0	795	0	0
Адуу	10	1	157	77 234	275	30
Үхэр	1	0	218	77 370	154	9
Хонь	612	24	3 195	753 115	3 785	466
Ямаа	900	264	2 971	714 659	3 471	451

Малын хээл хаялт, сувайралт. 2012 онд оны эхний хээлтэгч малын 0.8 хувьтай тэнцэх 8.2 мянган мал хээл хаяж, 4.4 хувьтай тэнцэх 968.9 мянган мал сувайрсан байна. Хээл хаясан хээлтэгч малын тоо 2011 онхоос 45.5 хувиар буюу 34.3 мянгаар, сувайрсан хээлтэгч малын тоо 2011 оныхоос 62.3 хувь буюу 13.6 мянгаар буурчээ.

Төл өгөөгүй хээлтэгч малын тоо 98.9 мянгад хүрч түүний 78.0 хувийг сувайрсан хээлтэгч, 22.0 хувийг хээл хаясан хээлтэгч мал тус тус эзэлж байна.

Хүснэгт 21.

Хээл хаяж, сувайрсан эх малын тоо

	Сувайрсан						Хээл хаясан					
	2007	2008	2009	2010	2011	2012	2007	2008	2009	2010	2011	2012
Бүгд	29.6	64.6	55.68	149.0	77.1	42.8	9.5	42.6	52.01	185.6	21.8	8.2
Ингэ	0	0.1	0.08	0.2	0.08	0.2	0	0	0.01	0.01	0.02	0.02
Гүү	4	6.9	5.1	8.8	5.6	3.7	0.8	4.4	2.5	8.6	0.8	0.5
Үнээ	3.3	6.1	3.8	6.8	5.2	2.9	0.9	2.3	1.6	4.1	0.7	0.3
Эм хонь	13.4	30.1	24.2	68.4	31.4	17.0	3	14.9	12.1	60.9	6.4	2.3
Эм ямаа	9	21.3	22.5	64.8	34.9	16.1	4.9	20.9	35.8	112.0	13.9	5.2

Аймгийн хэмжээнд төл өгөөгүй хээлтэгч малын тоо өмнөх оноос 1 дахин буурсан байна. Сумдаар авч үзвэл бүх сумдын хувьд төл өгөөгүй хээлтэгч малын тоо буурсан байна.


Хүснэгт 22.

Оны эхний хээлтэгчид хээл хаялт, сувайралтын эзлэх хувь

	Сувайрсан						Хээл хаясан					
	2007	2008	2009	2010	2011	2012	2007	2008	2009	2010	2011	2012
Бүгд	2.4	4.6	3.9	16.0	8.0	4.4	0.8	3.0	3.6	19.9	2.2	0.9
Ингэ	0.0	2.3	1.7	4.1	1.4	2.9	0.0	0.0	0.2	0.2	0.4	0.3
Гүү	8.4	14.3	9.9	24.5	13.3	8.8	1.7	9.1	4.9	24.0	1.9	1.1
Үнээ	7.1	12.5	7.8	22.5	15.0	8.4	1.9	4.7	3.3	13.6	2.0	0.9
Эм хонь	2.2	4.6	3.5	16.1	7.2	3.9	0.5	2.3	1.8	14.4	1.5	0.5
Эм ямаа	1.6	3.3	3.5	14.8	7.8	4.3	0.9	3.3	5.5	25.5	3.1	1.2

Зураг 12.

Хээл хаялт, сувайралт



Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь тэмээнээс бусад төрөл дээр алдагдсан хэвээр байна.

2012 онд 26.0 мянган хээлтүүлэгч мал тоологдож, 2011 оныхоос 4.2 мянган толгойгоор буюу 19.4 хувиар өссөн байна. 2011 оныхоос буур 11, бух 343, азарга 733, хуц 1393, ухна 1736 толгойгоор тус тус өсчээ.

Хүснэгт 23.

Хээлтүүлэгч малын тоо

	Хээлтүүлэгч мал						Үүнээс: шинээр тавьсан					
	2007	2008	2009	2010	2011	2012	2007	2008	2009	2010	2011	2012
Бүгд	37 128	41 050	41 894	16 913	21 775	25991	247	68	216	27	27	20
Буур	203	194	222	211	219	230	0	0	-	-	-	1
Азарга	6 679	6 926	7 078	5 283	5 744	6477	0	48	154	18	4	13
Бух	2 485	2 418	2 490	1 057	1 390	1733	0	20	62	8	6	1
Хуц	14 526	15 916	16 642	5 687	7 405	8798	154	0	-	-	2	4
Ухна	13 235	15 596	15 462	4 675	7 017	8753	93	0	-	1	2	1

Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-31 хээлтэгч ногдох ёстой атал 2012 онд аймгийн дунджаар 62 эм хонь, 62 эм ямаа ногдож, харилцан адилгүй үзүүлэлт гарч байна.

Хүснэгт 24.

Хээлтэгч хээлтүүлэгчийн тохироо

	Үржлийн норм	2007	2008	2009	2010	2011	2012
Ингэ	20-25	20	23	21	23	26	28
Гүү	12-15	7	7	7	7	7	8
Үнээ	35-45	19	20	20	29	25	24
Эм хонь	25-30	42	41	41	75	59	62
Эм ямаа	25-31	42	41	42	94	64	62

Малын хэрэглээний зарлага. 2012 онд оны эхний нийт малын 15.6 хувьтай тэнцэх 378.9 мянган малыг хэрэглээнд зарцуулсан байна.

Малын хэрэглээний зарлага 2011 оныхоос 4.4 мянган толгойгоор буюу 1.4 хувиар буурсан байна. Хэрэглээнд зарцуулсан малын тоо адуу, ямаа өсч бусад төрөл дээр буурсан үзүүлэлт гарсан байна.

Малтай нэг өрх дунджаар 16 толгой малыг хэрэглээнд зориулан зарцуулсан байна. Үүнийг аймгийн хэмжээний нийт өрхөөр тооцвол нэг өрхөд

дунджаар 12 толгой мал хэрэглээндээ зарцуулсан байна. Энэ үзүүлэлт нь урд оны түвшинд байна.

Хүснэгт 25.


Малын хэрэглээний зарлага

	2007	2008	2009	2010	2011	2012
	МЯН.ТОЛ					
Бүгд	404.8	549.9	864.0	248.8	383.3	378.9
Тэмээ	1.4	1.4	1.1	1.4	1.7	1.0
Адуу	9.9	14.9	23.7	1.0	2.1	7.8
Үхэр	11.7	19.5	27.9	1.7	9.1	6.6
Хонь	224.4	310.5	407.0	188.2	207.4	166.3
Ямаа	157.5	203.5	404.3	56.5	163.0	197.2
Оны эхний малд эзлэх хувь						
Бүгд	21.0	27.1	25.0	6.9	19.1	15.6
Тэмээ	11.0	8.3	8.0	9.2	11.4	6.2
Адуу	9.8	13.5	13.7	0.5	1.8	5.5
Үхэр	17.6	20.9	20.7	1.2	11.9	7.3
Хонь	25.6	27.8	25.9	11.1	23.1	15.8
Ямаа	17.9	28.8	25.9	3.6	17.9	17.5

Хэрэглээнд зарцуулсан малын 95.9 хувийг бог мал, 4.1 хувийг бод мал эзэлж байгаа бөгөөд оны эхний тэмээний 6.3 хувь, адууны 5.5 хувь, үхрийн 7.3 хувь, хонины 15.8 хувь, ямааны 17.5 хувийг хэрэглээнд зарцуулсан байна.

Зураг 13.

Малын хэрэглээний зарлага /мян.толгой/



**Зах зээлд худалдаж борлуулсан болон аж ахуйн дотоодод
хэрэглэсэн малын тоо**

	Зах зээлд худалдан борлуулсан						Аж ахуйн дотоодод хэрэглэсэн					
	2007	2008	2009	2010	2011	2012	2007	2008	2009	2010	2011	2012
Бүгд	140.6	181.7	369.2	153.3	179.4	217.8	265.7	270.6	313.6	215.3	180.2	190.1
Тэмээ	0.3	0.4	0.5	0.9	0.7	0.8	0.6	0.7	0.5	0.8	0.5	0.5
Адуу	6.4	6.6	12.7	7.4	7.5	9.1	7.6	9.6	9.8	7.6	5.4	5.4
Үхэр	6.6	7.2	9.6	5.9	6.8	7.2	8.9	13.3	13.9	9.4	6.2	5.8
Хонь	82.1	104.2	183.4	83.8	95.0	101.2	139.5	134.9	148.1	106.6	86.5	85.0
Ямаа	45.1	63.4	163	55.3	69.3	99.5	109.1	112.1	141.3	90.9	81.6	93.5

Малтай нэг өрх дунджаар 13 толгой малыг зах зээлд борлуулж, 11 толгой малыг өөрийн хүнсэндээ хэрэглэсэн байна.

Сүргийн бүтэц. 2012 оны байдлаар нийт сүргийн 33.2 хувь буюу 986.0 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 25.9 хувь буюу 768.4 мянган толгой нь нас гүйцсэн эр мал, 40.1 хувь буюу 1190.5 мянган толгой нь хээлтэгч мал, 0.9 хувь буюу 26.0 мянган толгой нь хээлтүүлэгч байна.

2012 оны сүргийн бүтэц

	Толгойгоор, мян.тол					Хувиар				
	Бүгд	Төл өсвөр насны мал	Нас гүйцсэн эр мал	Хээлтэгч	Хээлтүүлэгч	Төл өсвөр насны мал	Нас гүйцсэн эр мал	Хээлтэгч	Хээлтүүлэгч	
Бүгд	2970.7	986	768.4	1190.5	26	33.2	25.9	40.1	0.9	
Тэмээ	18.1	7.2	4.3	6.4	0.2	39.8	23.8	35.4	1.1	
Адуу	170.5	70.3	44.4	49.4	6.5	41.2	26.0	29.0	3.8	
Үхэр	114	49.8	20.6	41.9	1.7	43.7	18.1	36.8	1.5	
Хонь	1310.9	431.4	322.8	547.9	8.8	32.9	24.6	41.8	0.7	
Ямаа	1357.2	427.3	376.3	544.9	8.8	31.5	27.7	40.1	0.6	

Сүргийн бүтцийг 2011 онтой харьцуулахад төл, өсвөр насны малын нийт сүрэгт эзлэх хувийн жин дүнгээрээ 0.2 пунктээр буурч, харин нас гүйцсэн эр мал, хээлтэгч малын эзлэх хувийн жин өсч, хээлтүүлэгч малын эзлэх хувийн жин 2011 оны түвшинд байна.

Төл, өсвөр насны малын нийт сүрэгт эзлэх хувийн жин 2011 онтой харьцуулахад бод малын төрөл дээрээ өсч, бог малын төрөл дээр буурсан байна. Нас гүйцсэн мал бод малын төрөл дээрээ буурч, бог малын төрөл

дээрээ өссөн, хээлтэгч мал бог мал болон ингэ өсч гүү , үнээ буурсан, хээлтүүлэгч нь харин буур, азарга буурч, бух, хуц, ухна тус тус урд оны түвшинд хэвээр үзүүлэлтүүдтэй байна.

Хүснэгт 28.

Сүргийн бүтэц хувиар

	Төл, өсвөр насны					Нас гүйцсэн эр мал				
	2008	2009	2010	2011	2012	2008	2009	2010	2011	2012
Бүгд	28.9	32.0	14.8	33.4	33.2	29.4	27.2	37.9	25.7	25.9
Тэмээ	35.5	38.5	11.6	35.8	39.8	31.7	28.8	53.7	27.0	23.8
Адуу	37.0	39.7	8.3	35.8	41.2	31.0	28.5	55.4	30.4	26.0
Үхэр	42.5	44.0	16.8	41.1	43.7	19.4	19.5	42.1	19.2	18.1
Хонь	30.1	33.8	18.4	33.7	32.9	26.9	24.9	33.7	24.0	24.6
Ямаа	25.5	28.1	12.0	32.2	31.5	32.6	30.2	39.2	27.3	27.7

үргэлжлэл

	Хээлтэгч					Хээлтүүлэгч				
	2008	2009	2010	2011	2012	2008	2009	2010	2011	2012
Бүгд	40.5	39.6	46.4	39.9	40.1	1.2	1.2	0.8	0.9	0.9
Тэмээ	31.4	31.2	33.3	35.2	35.4	1.4	1.5	1.4	1.3	1.1
Адуу	28.0	28.0	31.5	29.8	29.0	4.0	3.9	4.7	4.0	3.8
Үхэр	36.3	34.8	39.6	38.2	36.8	1.8	1.8	1.4	1.5	1.5
Хонь	42.0	40.3	47.3	41.7	41.8	1.0	1.0	0.6	0.7	0.7
Ямаа	40.9	40.7	48.2	39.8	40.1	1.0	1.0	0.5	0.6	0.6

Зураг 14.

Сүргийн бүтэц, хувиар



II.3 МАЛЫН БЭЛЧЭЭР, ТЭЖЭЭЛИЙН ХҮРЭЛЦЭЭ, ХАНГАМЖ

Бэлчээрийн хүрэлцээ. Газрын албаны 2012 оны газрын нэгдмэл сангийн тайлангаар манай аймгийн бэлчээр хадлангийн талбай 5.7 сая га талбай болж, малын тоо хонин толгойд шилжүүлснээр 4.5 сая толгой тоологдож 2011 оныхоос 0.8 саяар өсчээ.

2012 онд 100 га хадлан, бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр 79 толгой мал ногдож байна.

Хүснэгт 29.


Бэлчээрийн хүрэлцээ хангамж

	2009	2010	2011	2012	2012/ 2011%
Хадлан бэлчээрийн талбай, мян.га	5 722.5	5 722.0	5 716.2	5 689.7	-0.5
100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо	93	53	64	79	23.4

100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 2011 оныхоос 15 толгой малаар өсчээ.

Зураг 15.

**100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин
толгойд шилжүүлсэн малын тоо**



2012 онд 100 га талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо аймгийн хэмжээний бүх суманд өссөн байна. Өмнөх онд аймгийн хэмжээнд 100 га талбайд хонин толгойд шилжүүлснээр 64 толгой мал ноогдож байсан бол энэ жил 79 болж өссөн байна. 2010 онд 53 ногдож байсан байна.

Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж. 2012 онд аймгийн хэмжээгээр тэжээлийн нэгжид шилжүүлснээр 43.5 мянган тонн тэжээл үйлдвэрлэсэн нь 2011 оныхоос 2.2 хувиар буюу 1.0 мянган тонноор өссөн байна. Бэлтгэсэн тэжээлийг нэр төрлөөр авч үзвэл гар тэжээл өмнөх оны бэлтгэсэн хэмжээнээс 1082.7 тн-оор, хужир шүү өмнөх оныхоо хэмжээнээс 1494.6 тн-оор, үр тарианы хаягдал 61.1 тн-оор тус тус буурч, байгалийн хадлан, таримал тэжээл, даршны ургамал, сүрэл, лай, хүнсний ногооны хаягдал тус бүр өссөн байна.

Хүснэгт 30.

Бэлчээрийн тэжээл, нэр төрлөөр

	2008	2009	2010	2011	2012	ТН 2012/ 2011%
Байгалийн хадлан	38 696.7	14 491.9	31 916.1	32 990	32833.9	99.5
Таримал тэжээл	197.3	32.1	41.2	861.1	2536.0	294.5
Даршны ургамал	18.35	9.7	12	194.2	303.3	156.2
Гар тэжээл	6 852.4	5 221.8	5 330.2	6 372.2	5289.5	83.0
Хужир шүү	5 945.9	6 013.3	5 311.2	3 476.1	1981.5	57.0
Хүнсний ногооны хаягдал	248	95	102	38.6	89.0	230.6
Үр тарианы хаягдал	15	0	50	170.9	109.8	64.2
Лай	5	3.7	4.2	4	9.9	247.5
Сүрэл	40	31.8	49.2	316	314.6	99.6

2011 онтой харьцуулахад бэлтгэсэн хадлан Бүрд, Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Тарагт, Уянга, Хужирт сумаас бусад сумдууд өссөн, гар тэжээл бэлтгэлт Баян-Өндөр, Бүрд, Баянгол, Есөнзүйл, Зүүнбаян-Улаан, Богд, Уянга, Хужирт сумдуудаас бусад суманд мөн өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 16.



Үйлдвэрлэсэн тэжээлийн бүтцээр авч үзвэл хүчит тэжээл, бүдүүн тэжээл, шүүст тэжээл бүгд өссөн, бусад тэжээл өмнөх оноосоо бага зэрэг буурсан байна.

Хүснэгт 31.

Тэжээлийн бүтэц, тэжээлийн хангамж

	2008	2009	2010	2011	2012
Бүгд	52 018.7	25 899.3	42 816.1	44 423.1	43467.5
Хүчит	6 867.4	5 221.8	5 380.2	6 543.1	5399.3
Шүүст	18.4	9.7	12.0	194.2	303.3
Бүдүүн	39 187.0	14 654.5	32 112.7	34 209.7	35783.4
Бусад	5 945.9	6 013.3	5 311.2	3 476.1	1981.5
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл, тэж.нэгж, кг	10.3	4.9	14.1	12.1	11.8

2012 онд хонин толгойд шилжүүлсэн нэг малд 11.8 кг тэжээл ногдож байгаа нь 2011 оныхоос 0.3 кг-аар буурсан байна.

II.4 ТЭЖЭЭВЭР АМЬТАД

2012 онд 174 гахай, 1578 шувуу тоологдсон нь өмнөх онтой харьцуулахад гахайн тоо 134-аар өсч, шувууны тоо 315-аар буурсан байна. Өмнөх онд

Баруунбаян-Улаан суманд 2 илжиг тоологдож байсан бол энэ жил илжиггүй болсон байна.

Хүснэгт 32.

Тэжээвэр амьтад, тэдгээрийг өсгөн үржүүлдэг өрхийн тоо

	2008	2009	2010	2011	2012	2012/2011	
						хувь	зөрүү
Гахай	181	159	113	40	174	4 дахин	134
Шувуу	431	347	1511	1893	1578	-16.6	-315
Илжиг	3	7	2	2	0	-	-2
Гахайтай өрхийн тоо	18	20	10	6	14	233.3	8
Шувуутай өрхийн тоо	24	14	13	17	15	-11.7	-2
Илжигтэй өрхийн тоо	1	2	1	1	-	-	-

2012 онд гахайтай өрхийн тоо 2011 оныхоос 8-аар өсч, шувуутай өрхийн тоо 2-оор буурсан байна. Өсгөн үржүүлж байгаа гахайтай өрхүүд Баян-Өндөр, Бат-Өлзий, Гучин-Ус, Зүүнбаян-Улаан, Тарагт, Хайрхандулаан, Хархорин, Арвайхээр суманд байна. Шувуутай буюу тахиатай өрхүүд Бат-Өлзий, Гучин-Ус, Нарийнтээл, Тарагт, Төгрөг, Хайрхандулаан, Хархорин, Арвайхээр сумдад байна.

III. ГАЗАР ТАРИАЛАН

2012 онд аймгийн хэмжээнд хаврын тариалалтаар нийт 4440 га талбайд үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалсан ба энэ нь урд оноос үр тариа тариалалт 62.2 хувь буюу 1307 га-аар, төмс тариалалт 7.5 хувиар буюу 23 га-аар, хүсний ногоо тариалалт 9.5 хувиар буюу 13.3 га-аар, тэжээлийн ургамал тариалалт 11.2 хувиар буюу 54.4 га-аар тус тус өссөн байна.

Хүснэгт 33.

Тариалсан талбай, га-аар						
	2009	2010	2011	2012	2012/2011	
					хувь	зөрүү
Нийт тариалсан талбай	1365	2761	3043	4440	145.9	1397
Үр тариа	981	1717	2100	3407	162.2	1307
Төмс	253	281	304	327	107.5	23
Хүнсний ногоо	132	142	146	160	109.5	13.3
Тэжээлийн ургамал	132	621	492	547	111.2	54.4

Намрын ургац хураалтаар 1848 га-аас 2983 тн үр тариа , 327.3 га-аас 3662.6 тн төмс, 159.5 га-аас 1991.7 тн хүнсний ногоо хураан авчээ. Өнгөрсөн оноос үр тариа 926.0 тн-оор , төмс 593.7 тн-оор, хүнсний ногоо 343.7 тн-оор тус тус илүү хураасан байна. Га-гийн ургац урд оноос үр тариа 0.3 пунктээр, төмс 1.1 пунктээр, хүнсний ногоо 1.2 пунктээр тус тусөндөр байна.

Хүснэгт 34.

Хураасан ургац, тн-оор						
	2009	2010	2011	2012	2012/2011	
					хувь	зөрүү
Үр тариа	702	1089	2057	2983	145.0	926.0
Төмс	2392	2655	3069	3663	119.3	593.7
Хүнсний ногоо	1446	1459	1648	1992	120.8	343.5
Тэжээлийн ургамал	371	701.4	858.7	2536	295.3	1677.3

ДҮГНЭЛТ

Малын тоо, толгой 2012 оны жилийн эцэст 2970.7 мянган толгой тоологдож, 2011 оныхоос 545.1 мянгаар буюу 22.5 хувиар өслөө. Үүний дотор тэмээ 18.1 мянга, адуу 170.5 мянга, үхэр 113.9 мянга, хонь 1310.9 мянга, ямаа 1357.2 мянга болж, тэмээ 14.2 хувь буюу 1.2 мянган толгой, адуу 20.9 хувь буюу

27.3 мянган толгой, үхэр 25.8 хувь буюу 14.3 мянган толгой, хонь 24.6 хувь буюу 155.1 мянган толгой, ямаа 20.5 хувь буюу 217.2 мянган толгойгоор тус тус өссөн байна.

Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр 98.6 тэрбумд хүрч, өмнөх онтой харьцуулахад 19.4 хувиар өслөө. 2012 онд нядалгааны жингээр 22.5 мянган тонн мах, 30.7 мянган литр сүү, 1.2 мянган тн хонины ноос, 0.3 мянган тонн ноолуур, 0.05 мянган тонн тэмээний ноос, 412.9 мянган ширхэг арьс шир үйлдвэрлэсэн нь махны үйлдвэрлэл нядалгааны жингээр 1.0 хувиар буурч, сүүний үйлдвэрлэл 23.0 хувиар, тэмээний ноос 8.0 хувиар, хонины ноос 17.3 хувиар, ямааны ноолуур 23.9 хувиар, арьс шир 10.6 хувиар тус тус өссөн байна.

Малтай өрх 17272 байгаа ба үүний 78.9 хувь буюу 13603 нь малчин өрх байна. Эдгээр өрхийн тоо 2011 оныхоос малтай өрх 4.4 хувиар буюу 61 өрхөөр нэмэгдэж, малчин өрх 7.9 хувиар буюу 1172 өрхөөр буурсан байна. Аймгийн нэг малтай өрхөд 172 толгой мал, нэг малчин өрхөд 218 толгой мал ноогдож байна.

Аймгийн хэмжээнд Баян-Өндөр сум 256.2 мянган толгой малаар тэргүүлж байна.

Том малын зүй бус хорогдол 8.1 мянга болж өмнөх оноос 13.8 мянган малаар буурсан, бойжсон төл 13.6 хувиар буюу 111.6 мянган толгой малаар өссөн, малын хэрэглээний зарлага 4.4 хувиар буурсан, хээлтэгч малын тоо өмнөх оноос 22.9 хувиар буюу 221.6 мянган толгойгоор өссөн үзүүлэлтүүд тус тус гарсан байна.

2012 оны байдлаар нийт мал сүргийн 89.8 хувийг бог мал, 10.2 хувийг бод мал эзэлж байгаа нь урд оны түвшинд байна. Бог малын дотор хонь 44.1 хувь, ямаа 45.7 хувийг эзэлж байгаа ба уламжлалт харьцаа сүүлийн жилүүдэд ихээхэн хэмжээгээр алдагдсаар байгаа ба 2012 онд хонин сүргийн тооны өсөлт ямаан сүргийн тооны өсөлтөөс 4.0 пунктээр илүү байна. 2012 оны малын тооны нийт өсөлтийн 47.5 хувийг хонин сүргийн тооны өсөлт, 42.3 хувийг ямаан сүргийн тооны өсөлт хангаж байгаа нь харьцангуй эерэг үзүүлэлт юм.

2010 онд нийт мал сүргийн 44.5 хувь нь хорогдож, сүргийн бүтцийн харьцаа ихээхэн алдагдсан. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь тэмээнээс бусад төрөл дээр алдагдсан хэвээр байна. Үржлийн нормоор бог малын нэг

хээлтүүлэгчид 25-31 хээлтэгч ногдох ёстой атал 2012 онд аймгийн дунджаар 62 эм хонь, 62 эм ямаа ногдож, харилцан адилгүй үзүүлэлт гарч байна.

2012 онд 26.0 мянган хээлтүүлэгч мал тоологдож, 2011 оныхоос 4.2 мянган толгойгоор буюу 19.4 хувиар өссөн байна. 2011 оныхоос буур 11, бух 343, азарга 733, хуц 1393, ухна 1736 толгойгоор тус тус өсчээ.

Аймгийн дүнгээр хаврын тариалалтаар 3406.5 га-д үр тариа, 327.3 га-д төмс, 159.5 га-д хүнсний ногоо тариалж, намрын ургац хураалтаар 1848 га-аас 2983 тн үр тариа, 327.3 га-аас 3662.6 тн төмс, 159.5 га-аас 1991.7 тн хүнсний ногоо хураан авчээ. Өнгөрсөн оноос үр тариа 926.0 тн-оор, төмс 593.7 тн-оор, хүнсний ногоо 343.7 тн-оор тус тус илүү хураасан байна. Га-гийн ургац урд оноос үр тариа 0.3 пунктээр, төмс 1.1 пунктээр, хүнсний ногоо 1.2 пунктээр тус тус өндөр байна.

Аж ахуйн нэгж, иргэд 32833.9 тн хадлан, 5289.5 тн гар тэжээл бэлтгэжээ. Энэ нь өнгөрсөн оноос хадлан 156.1 тн-оор, гар тэжээл 1082.7 тн-оор бага байна.

Мал аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлэх, мал сүргийн өсөлтөд нөлөөлж буй сөрөг нөлөөг багасгахын тулд малчдын хөдөлмөрийг нэгтгэх, ашиг шим багатай олон тооны мал биш ашиг шим өндөртэй цөөн тооны мал өсгөх, сүргийн бүтцийн зохистой харьцааг хангах, сүү мах, малын гаралтай түүхий эд боловсруулах жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, малыг эрсдлээс хамгаалах даатгалын системийг хөгжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Цаашлаад мал маллагааны арга ажиллагааг залуу үед сургах арга хэмжээ шаардлагатай байна.

Мөн нэг асуудал нь орон нутагт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг бэлтгэх төвлөрсөн цэгүүд, хадгалах, хөргөх, агуулах зоорийг бий болгох, сэргээн засварлах асуудал чухал байна.